

**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

**2009 оны 02 дугаар**  
**сарын 19-ний өдөр**

**Дугаар 38**

**Улаанбаатар хот**

“Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх,  
анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай”  
журам шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 8.1, 34.1.3 дахь заалт, Компанийн тухай хуулийн 13.3 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
  
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Үнэт цаасны хороо /хуучнаар/-ны “Журам тогтоох тухай” 1997 оны 22, “Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааны мэдээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 1997 оны 120, “Журам шинэчлэн найруулж батлах тухай” 1999 оны 74, Санхүүгийн зохицуулах хорооны “Журам батлах тухай” 2006 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журамд нэмэлт, өөрчлөлт оруулах” тухай, 2007 оны 120 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
  
3. Хуульч, үнэлгээчин, аудитын компанийг хүлээн зөвшөөрөх, үнэт цаас гаргагч компанийн эрх бүхий албан тушаалтныг тохиромжтой этгээд гэж үзэх тухай журмын төсөл боловсруулан энэ оны 1 дүгээр улиралд багтаан Хорооны хуралдаанд оруулахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.
  
4. Энэхүү журмыг олон нийтэд сурталчлахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т, мэргэжлийн байгууллагуудын хүрээнд сургалт зохион байгуулахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.
  
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**НИЙТЭД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ,  
ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНАЛ БОЛГОХ,  
ХУДАЛДАХ ТУХАЙ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь нийтэд санал болгон шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны үнэт цаасны бүртгэл /цаашид “үнэт цаасны бүртгэл” гэх/-д бүртгэх, үнэт цаасыг нийтэд санал болгох үнийг тогтоох, үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, худалдах, үнэт цаасны гүйлгээний тайланг Хороонд ирүүлэх, нийтэд мэдээлэх, ХК хуваах, нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан, хувьцааг хуваасан, нэгтгэсэн, бондын үлдэгдлийг хүчингүй болгосон тохиолдолд бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үнэт цаасны танилцуулгад анх гаргахаар төлөвлөж, хөрөнгийн биржид арилжаалахаар байршуулсан үнэт цаасыг анхдагч зах зээл дээр бүрэн арилжиж дуусах хүртэл тухайн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэхийг хориглоно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

1.3. Өмнө нь биет бус хэлбэрээр гаргасан үнэт цаасыг нэмж гаргахдаа мөн биет бус хэлбэрээр гаргана.

1.4. Үнэт цаасыг бүртгүүлэхээр бүрдүүлэх баримт бичиг, тавигдах шаардлага нь тухайн үнэт цаасны төрөл, үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллаганы байдал, үнэт цаасыг нээлттэй, хаалттай захиалгын аль хэлбэрээр гаргаж байгаагаас хамаарч өөр байж болно.

1.5. Энэхүү журмаар хоёрдогч зах зээлд арилжаалагдаж буй үнэт цаасыг худалдах болон худалдан авах захиалгыг хүлээн авах, арилжихтай холбогдсон харилцааг зохицуулахгүй.

1.6. Хороонд бүртгүүлээгүй аливаа үнэт цаасыг нийтэд санал болгон сурталчлах, үнэт цаасны зах зээл дээр арилжихыг хориглоно. Харин стратегийн болон хамтын хөрөнгө оруулалтын байгууллага, андеррайтерийн компанитай үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах талаар урьдчилан яриа, хэлэлцээр хийсэн үйлдлийг нийтэд санал болгон сурталчилсанд тооцохгүй.

**ХОЁР. НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА БОЛОН НЭМЖ ХУВЬЦАА, БОНД  
ГАРГАЖ БАЙГАА КОМПАНИД ТАВИХ ШААРДЛАГА, НИЙТЭД САНАЛ БОЛГОН  
ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

2.1. Нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргаж байгаа компани болон түүний андеррайтер дараах ажиллагааг хийж гүйцэтгэсэн, компани нь мөн энэ хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

2.2. Хувьцааг Хороонд бүртгүүлэхээр хандахын өмнө андеррайтер, үнэт цаас гаргагч хамтран дор дурьдсан ажиллагааг хэрэгжүүлэн, компанийн үйл ажиллагаанд дүгнэлт өгсөн байна.

2.2.1. Хороо хүлээн зөвшөөрсөн аудитийн компанитай гэрээ байгуулан, дараах дүгнэлт гаргуулсан байна:

2.2.1.1. нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан нь НББОУС-д нийцэж байгаа эсэх;

2.2.1.2. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь НББОУС-д нийцсэн тайлан гаргах шаардлага, хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын үр ашигтай байдлыг хангаж чадах эсэх;

2.2.1.3. үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулга, хавсаргасан бичиг баримтад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь бодит байдалд нийцэж байгаа эсэх.

2.2.2. Хороо хүлээн зөвшөөрсөн үнэлгээчинтэй гэрээ байгуулан компанийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн байна.

2.2.3. Хороо хүлээн зөвшөөрсөн хуульчтай гэрээ байгуулан дараах дүгнэлт гаргуулсан байна:

2.2.3.1. компанийн дүрэм болон хөдөлмөрийн, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан “Монголын компанийн засаглал кодекс”-т нийцсэн эсэх;

2.2.3.2. бусадтай байгуулсан хүчин төгөлдөр гэрээ, үүний дотор зээлийн болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээ зэрэг нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх;

2.2.3.3. сүүлийн 3 жилд хийсэн хэлцлийн дотор их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх, байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх;

2.2.3.4. үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз зэрэг нь хүчин төгөлдөр байгаа эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх;

2.2.3.5. дүрэм, журам, гэрээ, хэлцэл нь үнэт цаас гаргагчийн болон хөрөнгө оруулагчдын ашиг сонирхол, үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, Хорооноос тогтоосон журмын шаардлагад нийцэж байгаа эсэх;

2.2.3.6. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулга холбогдох бичиг баримт нь хууль тогтоомж, Хорооноос тогтоосон журмууд түүний дотор энэхүү журамд нийцэж байгаа эсэх;

2.2.3.7. танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хуулийн хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;

2.2.3.8. Мөн компанийн толгой, охин, хараат болон толгой компанийнх нь хараат болон охин компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлсон байна.

2.2.4. Хуульчийн гаргасан дүгнэлтийн дагуу компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч нь компани бол түүний эрх бүхий албан тушаалтнууд, хувь хүн бол тухайн хувь хүн нь ял шийтгэгдэж байгаагүй, хувьцаат компанийг удирдах дадлага чадвар,

мэдлэг туршлагатай этгээд мөн эсэх талаар андеррайтер бичгээр дүгнэлт гаргасан байна.

- 2.2.5. Мөн дээрх байдлаар тодорхойлсон аль нэг холбоотой компани нь арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хувьцаат компани бол компанийн засаглал нь кодекст тодорхойлсон зарчимд нийцсэн эсэх, ББСБ болон даатгалын компани бол тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг ханган хэвийн ажиллаж байгаа эсэх зэргийг 2.1.1.4-т заасан дүгнэлтийг гаргахдаа харгалзана.
- 2.2.6. ББСБ болон даатгалын компани нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг ханган хэвийн ажиллаж байгаа эсэх талаарх тодорхойлолтыг Хорооны холбогдох газрууд гаргана.
- 2.2.7. Андеррайтерийн компанийн шинжээчид компанийн үйл ажиллагаа явуулж байгаа зах зээл, уг зах зээлд үнэт цаас гаргагчийн эзлэх байр суурийн талаар дэлгэрэнгүй судалгаа, шинжилгээ хийж, бизнесийн ирээдүйн боломжид үнэлэлт дүгнэлт өгч, бизнесийн үнэлгээ хийсэн байна. Андеррайтерийн компани нь төрийн эрх бүхий байгууллагаас эрх авсан үнэлгээчингүй бол үнэлгээчинтэй гэрээ байгуулан бизнесийн үнэлгээ хийлгэсэн байна.

2.3. Нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах компани нь хугацаа хэтэрсэн өргүй байх бөгөөд /авлага бүхий этгээдтэй харилцан тохирсны дагуу өрийг хувьцаагаар солихоор хувьцаа гаргаж байгаа компанид энэ заалт хамаарахгүй/ хувьцааны борлуулалтаас олохоор төлөвлөж буй хөрөнгийн хэмжээнээс хамаарч дараах шаардлагыг хангасан байна:

Хувьцааны борлуулалтаас олохоор төлөвлөж буй хөрөнгийн үнийн дүн нь:

- 2.3.1. Хувьцааны борлуулалтаас олохоор төлөвлөж буй хөрөнгийн үнийн дүн нь 3 тэрбум хүртэл төгрөг бол 1-ээс доошгүй жил үйл ажиллагаагаа явуулсан байх, мөн сүүлийн жилийн татварын өмнөх ашгийг цэвэр өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа нь 5 хувиас багагүй байх;
- 2.3.2. Хувьцааны борлуулалтаас олохоор төлөвлөж буй хөрөнгийн үнийн дүн нь 3 -10 тэрбум төгрөг бол 3-аас доошгүй жил үйл ажиллагаагаа явуулсан байх мөн сүүлийн 3 жилийн татварын өмнөх дундаж ашгийг сүүлийн 3 жилийн дундаж цэвэр өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа буюу өөрийн хөрөнгийн дундаж өгөөж нь 5 хувиас багагүй байх;
- 2.3.3. Хувьцааны борлуулалтаас олохоор төлөвлөж буй хөрөнгийн үнийн дүн нь 10 тэрбум төгрөгөөс дээш бол 5-аас доошгүй жил үйл ажиллагаагаа явуулсан байх мөн сүүлийн 5 жилийн татварын өмнөх дундаж ашгийг сүүлийн 5 жилийн дундаж цэвэр өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа буюу өөрийн хөрөнгийн дундаж өгөөж нь 5 хувиас багагүй байх;

2.3.4. */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор хассан/*

- 2.3.5. Улс орны эдийн засгийн тогтвортой байдал, өсөлт, хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц үйлдвэрлэл, үйлчилгээний төсөл хэрэгжүүлэхээр байгуулагдсан, төсөл нь хэрэгжих шатандаа байгаа, өөрөөр хэлбэл борлуулалт хийж эхэлж байгаа буюу эхлээгүй байгаа компанид энэ журмын 2.3.1-2.3.4-т заасан шаардлага хамаарахгүй бөгөөд ийм компани нь дараахь шаардлагыг хангасан байна:

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

- 2.3.5.1. Төсөл цаашид тогтвортой хэрэгжихэд шаардлагатай санамж бичиг, гэрээ, хэлцлийг бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч нартай байгуулсан;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

- 2.3.5.2. төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах тусгай зөвшөөрлийг авсан;
  - 2.3.5.3. төслийн техник эдийн засгийн үндэслэлийг андеррайтерийн компани зөвшөөрсөн;
  - 2.3.5.4. компанийн эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд байх;
  - 2.3.5.5. Компанийн засаглалын журмуудаа боловсруулж баталсан.
- 2.3.6. Нийтэд санал болон хувьцаа гаргах арилжааны банк нь энэ хэсэгт зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна.
- 2.3.6.1. нийтэд санал болгон хувьцаа гаргах асуудлаар Монголбанкнаас зөвшөөрөл авсан;
  - 2.3.6.2. сүүлийн 8 улирал дараалан Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж ажилласан бөгөөд энэ тухай Монголбанк тодорхойлолт гаргасан;
  - 2.3.6.3. олон улсад хүлээн зөвшөөрсөн банкны сайн засаглалын зарчим, монголын компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн дотоод журмуудаа боловсруулж баталсан.

2.4. Нийтэд санал болгон үнэт цаас гаргах компани болон түүний хувьцааны хяналтын багцыг хөрвүүлэн эзэмших этгээд, Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн гишүүд, гүйцэтгэх захирлаар ажиллах этгээд нь татварын болон хугацаа хэтэрсэн зээлийн өргүй, төлбөрийн чадвартай, эрх бүхий албан тушаалд ажиллаж байсан болон ажиллаж байгаа компани нь сайн засаглалтай, татвараа хугацаанд төлж байсан тухай Зээлийн мэдээллийн сан, холбогдох татварын алба, Монголын хөрөнгийн биржийн тодорхойлолт авсан байна.

2.5. Нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргах компани нь дараах шаардлагыг хангасан байна.

- 2.5.1. Хугацаа хэтэрсэн өргүй;
- 2.5.2. Компанийн нийт гаргасан хувьцааны 70-аас дээшгүй хувийг нэг этгээд дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэггүй байх;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

- 2.5.3. Хороо болон Хөрөнгийн бирж компанийн засаглалыг нь хангалттай гэж үнэлсэн, хяналтын багц эзэмшигчид нь хугацаа хэтэрсэн өргүй, ТУЗ-ийн дарга, болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан нь Хороо “тохиромжтой” гэж үзсэн этгээд байх.
- 2.5.4. Монголын компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн дараах дотоод журмуудыг эрх бүхий байгууллагаар батлан мөрдөж хэвшсэн байна:
  - 2.5.4.1. Хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах журам;
  - 2.5.4.2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
  - 2.5.4.3. Дотоод хяналтын журам;
  - 2.5.4.4. Мэдээллийн үйл ажиллагааны журам;
  - 2.5.4.5. Ногдол ашгийн бодлого.

2.5.5. /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор хассан/

2.6. Хөрөнгө оруулагчидтай урьдчилан тохирсны дагуу хаалттай хүрээнд худалдах, өрийг хувьцаагаар солих, эсхүл ногдол ашгаа хувьцаа хэлбэрээр олгохоор нэмж хувьцаа гаргаж байгаа тохиолдолд энэ журмын 2.5.4-т заасан шаардлагыг хангасан байна. Эдгээр тохиолдолд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх эсэхийг “Компанийн тухай хуулийн 38.8-д заасны дагуу шийдвэрлэж, энэ тухай хувьцаа нэмж гаргах шийдвэртээ зааж, хэрэгжүүлэх бол журмыг тогтоосон байна.

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.7. Нийтэд санал болгон бонд гаргаж байгаа компани нь энэ зүйлийн 2.2.1-2.2.3, 2.3-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд бондын борлуулалтаас олохоор төлөвлөж байгаа хөрөнгийн дүн нь компанийн сүүлийн балансаар байгаа цэвэр өөрийн хөрөнгийн дүнгээс илүүгүй байна.

2.8. Дээрх шаардлагыг хангасан компани түүний андеррайтер хамтран үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд ирүүлнэ. Үнэт цаас бүртгүүлэх хүсэлт нь дараах баримт бичгээс бүрдэнэ.

2.8.1. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл;

2.8.2. Үнэт цаасны танилцуулга;

2.8.3. Хуульч, аудитор, үнэлгээчин, андеррайтерийн дүгнэлтүүд;

2.8.4. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл, танилцуулгад тусгасан мэдээллийг нотлох баримтууд;

2.8.5. Хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт.

2.9. Энэхүү журмын 2.8-д заасан баримтыг бичмэл хэлбэрээр 2 хувь үйлдэж ирүүлэх бөгөөд тэдгээрийн нэг нь эх хувь байна. 2.8.1- 2.8.2-т заасан бичиг баримтыг цаасан хэлбэрээс гадна электрон хэлбэрээр бэлтгэж ирүүлнэ.

2.10. Энэхүү журмын 2.8-д заасан багц бичиг баримт нь албан бичгийн стандартын шаардлагыг хангасан байхаас гадна дараах байдлаар эмхлэгдсэн байна:

2.10.1. энэхүү журмын 2.8-д заасан дарааллын дагуу эмхэтгэн хавтаслаж, нэгдсэн товъёог хийсэн байна;

2.10.2. өргөдөл, танилцуулга болон бусад хавсаргасан баримт бичгийн хуудас бүрийг дугаарлаж, нүүр бүрийн баруун доод хэсэгт үнэт цаас гаргагч болон андеррайтерийн компанийн тэмдэг дарж, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, огноог тэмдэглэсэн байна;

2.10.3. маягтын дагуу бөглөх баримтыг засваргүй, бүрэн бөглөсөн байна;

2.10.4. баримт бичгийн эх хувь нь гадаад хэл дээр үйлдэгдсэн бол албан ёсны Монгол орчуулгыг хавсаргасан байна;

2.10.5. нэг хавтсанд 400-с дээшгүй хуудас баримт байхаар хавтаслана.

2.10.6. хуулбар баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх шаардлагатай бол зохих журмын дагуу нотариатаар гэрчлүүлсэн байна;

2.10.7. үг үсэг, утга, найруулга, тооцооллын алдаагүй, мэдээлэл, тооцоо нь хоорондоо зөрүүгүй байна.

2.11. Дээрх шаардлагыг хангаагүй нь баримт бичгийг хүлээн авахаас татгалзах, буцаах үндэслэл болно.

2.12. Үнэт цаас гаргагчийн төлсөн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг буцаан олгохгүй.

2.13. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 2.8.1-д заасан өргөдлийг энэхүү журмын хавсралт 1-д заасан маягтын дагуу үйлдэх ба өргөдөлд хавсралтад заасан мэдээллийг тусгасан байна.

2.14. Өргөдлийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авсан Хорооны ажилтан хүлээн авсан тухай тусгай тэмдэглэлийг бөглөнө.

2.15. Үнэт цаасны танилцуулгын эхэнд түүний гол агуулгыг тусгасан товч мэдээлэл /цаашид “товч танилцуулга” гэх/-ийг энэхүү журмын 2-р хавсралтад заасан маягтын дагуу үйлдэж хавсаргана.

2.16. Товч танилцуулгад “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.1-д заасны дагуу нийтэд санал болгон худалдахаар гаргаж буй энэхүү үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдлийн талаар аливаа баталгаа гараагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.” гэсэн анхааруулгыг заавал оруулсан байна. Энэхүү анхааруулгыг үнэт цаасны товч танилцуулгад байршуулахдаа улаан өнгөөр бусад мэдээлэлээс ялгархуйц байдлаар тодруулан тусгасан байна.

2.17. Нийтэд санал болгон гаргах үнэт цаасны тухай танилцуулга нь үндсэн хоёр хэсгээс бүрдэх ба түүнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.3, 7.4-д зааснаас гадна дор заасан мэдээллийг тусган, холбогдох баримт бичгийг хавсаргана. /Мэдээллийн агуулгад тавих шаардлагыг IOSCO-гийн зарчимд нийцүүлэн 3-р хавсралтаар тогтоов/

2.18. Танилцуулгын эхний хэсэгт үнэт цаас гаргагчийн талаар дараахь мэдээллийг тусгаж холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.

2.18.1. үнэт цаас гаргагчийн нэр, хаяг, түүх /байгуулагдсан огноо, байгуулагдсанаас хойш хуульд заасан хэлбэрээр өөрчлөн байгуулагдаж байсан бол энэ тухай мэдээлэл/, компанийн амьдралд гарч байсан томоохон өөрчлөлтүүд /хяналтын багц эзэмшигч нь өөрчлөгдөж байсан, үйлдвэр үйлчилгээний үндсэн чиглэлээ өөрчлөхөд хүргэсэн томоохон үйл явдлууд/, салбар, төлөөлөгчийн газар байгуулсан, охин, хараат компанитай болсон, өөрийн хөрөнгийн хэмжээ нь 20-аас дээш хувиар нэмэгдсэн, хорогдсон тохиолдлууд түүний шалтгаан /их хэмжээний хохирол, алдагдал хүлээсэн, эсхүл гэнэтийн ашиг олсон, томоохон хувь нийлүүэгч нэмэгдсэн, хувь нийлүүлэгч нь хөрөнгөө эргүүлэн татсан г.м./

- үйл ажиллагааны төрөл, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл, үйлдвэрлэдэг гол нэрийн бүтээгдэхүүн, гол үйлчилгээний тухай мэдээлэл, сүүлийн 3 жилд шинээр үйлдвэрлэсэн гол нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарсан гол өөрчлөлт,

- үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй болон явуулахаар төлөвлөж буй зах зээлийн нөхцөл байдал, энэ зах зээлд тухайн компанийн эзлэх байр суурь, борлуулалтын хувь хэмжээний талаарх судалгаа, SWOP шинжилгээ,

- компанийн үйл ажиллагаа улирлын шинж чанартай эсэх, тийм бол үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд ямар нөлөөтэй

2.18.2. үнэт цаас гаргагчийн зохион байгуулалт, удирдлагын бүтэц, салбар, төлөөлөгчийн газар, нэгжийн тухай танилцуулга;

2.18.3. үнэт цаас гаргагчийн хяналтын багц хувьцаа эзэмшигч, /үүсгэн байгуулагчид/ эрх бүхий албан тушаалтны нэр, эрхэлж буй албан тушаалын тухай мэдээлэл;

- 2.18.4. энэ журмын 2.2.1-д заасан дүгнэлтийг гаргахад оролцсон аудитийн компанийн тухай мэдээлэл, түүний эрх бүхий албан тушаалтан нь үнэт цаас гарагч болон түүний эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой эсэх тухай мэдээлэл
- 2.18.5. үнэт цаас гаргагчийн томоохон харилцагчдын тухай мэдээлэл, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан нь үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой эсэх, компанийн хувьцааны 5-аас дээш хувийн багцыг эзэмшдэг эсэх тухай мэдээлэл
- 2.18.6. Компанийн хуулийн зөвлөхийн болон энэ журмын 2.2.3-т заасан дүгнэлтийг гаргасан хуулийн компанийн тухай мэдээлэл;
- 2.18.7. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаагаа явуулах хууль зүйн орчин, тусгай зөвшөөрөл, лиценз, эрхийн хүчин төгөлдөр байдлын талаарх мэдээлэл;
- 2.18.8. Компанийн засаглалын кодексийг хэрхэн мөрдөж буй талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан дотоод журмууд;
- 2.18.9. Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийн тухай мэдээлэл. Хэрэв уг үнэт цаасыг гаргах нь тухайн компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохоор бол шийдвэрийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргасан тухай мэдээлэл;
- 2.18.10. Сангийн сайдын 2004 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 248 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлан, түүний тодруулга бэлтгэх заавар”, Хорооны 2008 оны 6 дугаар сарын 12-ны 143 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагч, үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах байгууллагад мөрдөх дансны үлгэрчилсэн жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, санхүүгийн тайлангийн тодруулгын маягт”-д заасан нэмэлт тайлбар, тодруулгыг бүрэн тусгасан сүүлийн 3 жилийн болон үнэт цаасыг бүртгүүлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахын өмнөх улирлын аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, санхүүгийн гол үзүүлэлтүүд, аудиторын дүгнэлт;
- 2.18.10.1. хувьцаагаа анх удаа нийтэд санал болгон бүртгүүлэхээр хүсэлт гаргаж байгаа компани нь шинээр байгуулагдаж байгаа бөгөөд үүсгэн байгуулагч нь аж ахуйн нэгж бол сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүд, тайлбар, тодруулгын хамт, иргэн бол банкинд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй болох тухай мэдээлэл, холбогдох тодорхойлолтууд;
- 2.18.10.2. энэ хэсэгт компанийн менежментийн баг хариуцан гүйцэтгэж, ТУЗ-өөс баталсан “Санхүү эдийн засгийн үзүүлэлтийн талаарх менежментийн судлагаа, дүгнэлт”-ийг хавсаргасан байна. Уг дүгнэлтийг 3-р хавсралтын V дах хэсэгт тусгасан чиглэлээр бэлдэнэ.
- 2.18.11. үнэт цаас гаргагч компани болон түүний толгой, охин, хараат компани болон хяналтын багцыг эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэл;
- 2.18.12. Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан журмын дагуу өрийг хувьцаагаар сольж байгаа бол энэ тухай хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэр, өрийг хувьцаагаар солих төсөл, зээлдүүлэгч харилцагчийн зөвшөөрөл, өр үүссэнтэй холбогдох болон нягтлан бодох бүртгэлд тусгасан тухай мэдээлэл, эдгээр баримтыг шалгасан тухай аудиторын дүгнэлт;



- 2.18.13. үнэт цаасыг хаалттай хүрээнд санал болгон гаргах үед төлбөрийг эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хийхийг зөвшөөрсөн бол төлбөрт хүлээн авч буй хөрөнгийн жагсаалт, эдгээр хөрөнгө нь компанид ямар шалтгаанаар зайлшгүй хэрэгтэй болох тухай тайлбар, танилцуулга, тэдгээрийн үнэлгээний талаар хөндлөнгийн үнэлгээний байгууллагын дүгнэлт, үнийг батлах тухай ТУЗ-ийн шийдвэрийг ямар мэдээлэлд үндэслэн гаргасан болох талаар тайлбар, уг шийдвэрийн хуулбар;
- 2.18.14. Өрийг хувьцаагаар солих болон хаалттай хүрээнд санал болгон үнэт цаас гаргаж байгаа бол хувьцааг худалдаж, арилжихаар тооцсон үнийг тогтоосон үндэслэл, тооцоо;
- 2.18.15. Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасан шаардлагын дагуу хувьцаагаа нийтэд санал болгон худалдахаар бүртгүүлж байгаа бол орд газрын нөөцийг бүртгэх тухай “Эрдэс баялагийн зөвлөл”-ийн дүгнэлт, түүний үндэслэл болсон хайгуул судалгааны ажлын тайлангууд;
- 2.18.16. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн үнэлгээний талаар Хорооноос хүлээн зөвшөөрсөн эрх бүхий үнэлгээний байгууллагын гаргасан дүгнэлт, үнэлгээний тайлан;
- 2.18.17. Тодорхой төсөл хэрэгжүүлэхээр үнэт цаас гаргаж байгаа бол төсөл, түүний техник эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоо, төслийг хэрэгжүүлэх бодит нөхцөлийг хангасан тухай танилцуулга, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа эрхлэх бол тусгай зөвшөөрөл, газрын зөвшөөрөл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, уг үнэлгээний талаарх холбогдох төрийн байгууллагын дүгнэлт;
- 2.18.18. Эрсдэлийн шинжилгээ: үнэт цаас худалдан авсан хөрөнгө оруулагчдад учирч болох бүх төрлийн эрсдэлийн талаар тодорхой шинжилгээ хийж, дэлгэрэнгүй тайлбарласан байна. Эрсдэлийн шинжилгээг дараах чиглэлээр хийсэн байна:
- 2.18.18.1. үнэт цаас гаргагчийн эрхэлж буй бизнесийн салбарын эрсдэл;
- 2.18.18.2. бизнес эрхэлж буй улс орны төрийн бодлого, тогтолцоо, улс төрийн нөхцөл байдалтай холбоотой эрсдэл;
- 2.18.18.3. компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвартай холбоотой эрсдэл;
- 2.18.18.4. компанийн үнэт цаас зах зээлийн эрэлттэй холбогдон үүсч болох эрсдэл;
- 2.18.18.5. компанийн гүйцэтгэх удирдлагын шийдвэрээс хамааралтай байдлын эрсдэл;
- 2.18.18.6. ур чадвар, дадлага туршлагатай, мэргэшсэн ажиллах хүчний хангамжай холбогдсон эрсдэл;
- 2.18.18.7. өрсөлдөөний ердийн бус нөхцөл байдалтай холбогдсон эрсдэл;
- 2.18.18.8. компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий лицензи, тусгай зөвшөөрөл, гэрээний хугацаатай холбоотой эрсдэл;
- 2.18.18.9. тодорхой хязгаарлагдмал хүрээний эсхүл цөөн тооны бэлтгэн нийлүүлэгч, үйлчлүүлэгч, худалдан авагчаас хамааралтай байдлын эрсдэл;
- 2.18.18.10. мөнгөн гүйлгээ, хөрвөх чадвартай холбоотой эрсдэл;
- 2.18.18.11. менежментийн багийн дадлага туршлагатай холбоотой эрсдэл;

- 2.18.18.12. үнэт цаас гаргагчийн бизнестэй холбоотой эрсдэлийн талаарх дүгнэлт;
- 2.18.18.13. хүрээлэн байгаа орчны болон эрүүл ахуйн эрсдэл;
- 2.18.18.14. хяналтын багц эзэмшигчдийн шийдвэрээс хамааралтай байдлын эрсдэл
- 2.18.18.15. хяналт зохицуулалт, эдийн засаг улс төрийн эрсдэл
- 2.18.18.16. санхүүгийн түүх
- 2.18.18.17. үнэт цаасыг худалдан авах ирээдүйн хөрөнгө оруулагчдын шийдвэрт нөлөөлж болох бусад бүхий л чухал үйл явдал
- 2.18.18.18. үнэт цаасны өнөөгийн эзэмшигчид нь үнэт цаасны үнээс дээгүүр үнээр нэмэлт санхүүжилт хийх үүрэг үүсэх эрсдэл байгаа бол энэ талаар мэдээлнэ. Эрсдэлийн тухай мэдээллийг танилцуулгад тусгахдаа нөлөө үзүүлэх хир хэмжээг харгалзан дэс дарааллыг тогтоосон байна. Эрсдэлийн хүчин зүйлсийг тусгахдаа элдэв тайлбар хийх зэргээр ач холбогдол, үр дагаварыг бууруулах оролдлого хийхийг хориглоно.

2.19. Танилцуулгын хоёрдахь хэсэгт гаргаж буй үнэт цаасны талаар дараахь мэдээллийг тусгана:

- 2.19.1. үнэт цаасны төрөл, хэлбэр, нэг бүрийн нэрлэсэн үнэ, нийт гаргах үнийн дүн;
- 2.19.2. үнэт цаас эзэмшигчийн эрх;
- 2.19.3. өрийн бичиг /бонд/ гаргаж байгаа бол хугацаа, хүүгийн хэмжээ, хүү нь тогтмол, хөвөх зэргийн аль нь болох, хүү төлөх хугацаа, хугацаанаас нь өмнө эргүүлэн татах нөхцөлтэй эсэх;
- 2.19.4. өрийн бичиг гаргагчаас хүлээх үүрэг, компанийн өөрийн хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө бусад этгээдээс гаргах барьцаа, батлан даалт, тэдгээрийн зөвшөөрөл;
- 2.19.5. Үнэт цаасыг анхдагч зах зээлд ямар аргаар нийтэд санал болгох /хувьцааны захиалга авах, тогтоосон үнээр санал болгох, дуудлагаар худалдах/ үнэт цаасны захиалга авах, үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдах үнийг тодорхойлох, үнэт цаасыг хуваарилах, анхдагч зах зээлийн хэлцлийг гүйцэтгэх журам;
- 2.19.6. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах арга хэлбэр, байршуулж эхлэх, дуусах /захиалга авч эхлэх, дуусах/ хугацаа, уг хугацааг сунгах, богиносгох нөхцөл, журам, санал болгох үнийг тогтоох, нийтэд таниулан сурталчлах арга хэлбэр;  
Хэрэв өргөдөл ирүүлэх үед анхдагч зах зээлд байршуулж эхлэх хугацааг тодорхой тогтоох боломжгүй байгаа бол уг хугацааг тогтоох журмыг тайлбарласан байна.
- 2.19.7. Үнэт цаасыг худалдан борлуулснаас олохоор төлөвлөж буй цэвэр орлогын хэмжээ, уг орлогыг хэрхэн зарцуулах тооцоо, зарцуулалтын төрөл тус бүрээр;
- 2.19.8. Төлөвлөж байгаа арга хэмжээг санхүүжүүлэхэд үнэт цаас гаргалтын орлого хүрэлцэхгүй бол дутагдаж байгаа хэсгийг хэрхэн санхүүжүүлэхээр тооцоолж байгаа, эх үүсвэр тус бүрээр зардлын тооцоог хийж, хөрөнгө оруулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан байна.
- 2.19.9. Орлогыг бизнесийн ердийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээс өөрөөр зарцуулах, тухайлбал шинэ салбарт үйл ажиллагаа явуулах, шинэ тоног төхөөрөмж бусад хөрөнгө худалдан авахад зарцуулахаар төлөвлөж байгаа бол худалдан авахтай холбогдсон тооцоо, судалгаа, гэрээ хэлцэл. Эдгээр хөрөнгийг худалдан авах нь сонирхлын зөрчилтэй хэлцэл болох бол энэ тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

- 2.19.10. Орлогыг шинэ бизнесийг худалдан авахад зарцуулах бол тухайн бизнесийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, худалдан авалтын үйл ажиллагааны эрх зүйн орчингийн талаар мэдээлэл;
- 2.19.11. Орлогын тодорхой хэсгийг өр төлбөрийг барагдуулахад зарцуулахаар төлөвлөж байгаа бол тухайн өрийг төлж дуусгах ёстой хугацаа, хүүгийн хэмжээ, тухайн өр нь юутай холбоотой үүссэн, зээлийн өр бол зээлийг юунд зарцуулсан тухай дэлгэрэнгүй мэдээлэл
- 2.19.12. Орлогыг зарцуулах тодорхой төлөвлөгөө байхгүй бол хувьцаагаа нийтэд санал болгож байгаа шалтгаан.

2.20. Өрийг солихоор нэмж хувьцаа гаргаж байгаа бол энэ зүйлийн 2.16, 2.18.18 болон 2.19.4-2.19.10, 2.19.12 дах заалтууд хамаарахгүй.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

2.21. Бүх хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг олгохоор хувьцаа нэмж гаргаж байгаа бол энэ зүйлийн 2.20-д зааснаас гадна 2.18.12-2.18.18 дах заалтууд хамаарахгүй.

2.22. Хууль тогтоомжид заасны дагуу бүртгүүлэх зөвшөөрлийн хураамж төлсөн баримтыг өргөдөлд хавсарган ирүүлнэ.

## **ГУРАВ. НИЙТЭД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ ХҮСЭЛТИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**

3.1. Хороо үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлт болох өргөдөл, үнэт цаасны танилцуулга зэрэг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.3, 7.4 болон энэхүү журамд заасан шаардлагыг хангасан холбогдох баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногт шийдвэрлэх бөгөөд хугацааг энэ журмын 2 дугаар хэсэгт заасан баримт бичиг 3-р хавсралтаар тогтоосон шаардлагад нийцэж, бүрэн бүрдсэн өдрөөс эхлэн тооцно.

3.2. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авч, бүрдлийн шаардлага хангасан эсэх, үнэт цаас гаргагч нь энэ журмаар тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг ирүүлсэн баримтын хүрээнд шалгах ажиллагааг Хорооны мэргэжилтэн өргөдөл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан хянана.

3.3. Энэхүү журмын 3.2-г заасан асуудлыг тогтооход шаардлагатай баримт материал ирүүлээгүй, баримт материалууд нь хоорондоо зөрүүтэй, эсхүл үнэт цаас гаргагч нь энэ журмаар тогтоосон шаардлагыг хангахгүй байгаа бол чухам ямар бичиг баримтыг дутуу ирүүлсэн, ямар мэдээлэл зөрүүтэй байгаа, ямар шаардлагыг хангаагүй тухай дэлгэрэнгүй дурьдсан албан бичиг хүргүүлж, ирүүлсэн баримтын нэг хувийг өргөдөл гаргагчид буцаана.

3.4. Үнэт цаас гаргагч нь энэ журмаар тогтоосон шаардлага, шалгуурыг хангахгүй байгаа бол үнэт цаасыг бүртгэхээс татгалзах тухай шийдвэрийн төсөл бэлдэж, Хорооны хуралдаанд оруулах бөгөөд энэ талаар үнэт цаас гаргагчид албан тоотоор урьдчилан мэдэгдэж, тайлбар авсан байхаас гадна Хорооны хуралдаанд тайлбараа гаргах боломж олгоно.

3.5. Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь бүрдлийн шаардлага хангасан, үнэт цаас гаргагч нь энэ журмаар тогтоосон шаардлагыг хангасан гэж үзвэл өргөдлийг хянах ажиллагааг гүйцэтгэнэ. Энэ ажиллагааг 15 хоногт багтаан гүйцэтгэнэ.

3.6. Хорооны үнэт цаасны зах зээл хариуцсан газрын даргын томилсон ажлын хэсэг 3.4-т заасан хугацаанд үнэт цаас гаргагчийн байдалд газар дээр нь үзлэг хийж, дүгнэлт өгсөн байна.

3.7. Энэхүү журмын 3.2 болон 3.5-т заасан ажиллагааг гүйцэтгэх явцад үнэт цаас гаргагчаас нэмэлт бичиг баримт, тайлбар, тодруулга шаардсан тохиолдолд уг шаардлагыг мэдэгдсэн өдрөөс хойш үнэт цаас гаргагчаас холбогдох материалыг ирүүлэх хүртэл хугацаанд энэхүү журмын 3.1-д заасан хугацааг түр зогсооно.

3.8. Энэхүү журмын 3.3-т заасан шаардлагад хариу ирүүлэх хугацааг заах бөгөөд үнэт цаас гаргагчаас хугацааг сунгах тухай хүсэлт юмуу шаардлагын хариуг тогтоосон хугацаанд ирүүлээгүй нь хүсэлтийг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоож, буцаах үндэслэл болно.

3.9. Хорооны ажлын алба нь үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг хянаж байгаа явцын талаар Хорооны дарга, орон тооны гишүүдийг мэдээллээр хангаж ажиллана.

3.10. Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь бүртгүүлэхээр өргөдөл гаргасан үнэт цаасыг Хорооны ажлын албанд танилцуулах ажиллагааг Хорооны хуралдаанаас өмнө хийх бөгөөд танилцуулга хийх хугацааг өргөдөл хүсэлтийг хянаж байгаа газрын дарга тогтоон мэдэгдэнэ.

3.11. Энэхүү журмын 3.5-т заасан ажиллагааг гүйцэтгэсэн мэргэжилтэн үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлтийг зөвшөөрөх боломжтой эсэх талаар саналаа бэлтгэж, газрын орлогч дарга, дарга, Ажлын албаны даргад танилцуулж, Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх танилцуулга, шийдвэрийн төслийг бэлдэнэ. Танилцуулга шийдвэрийн төсөлтэй Хорооны дарга, орон тооны гишүүд танилцаж, Хорооны хуралдаанд оруулан хэлэлцүүлэх зөвшөөрлийг Хорооны дарга өгнө.

3.12. Хорооны шийдвэрийн төсөл, танилцуулгад 4-р хавсралтад дурьдсан мэдээллийг тусгана.

3.13. Үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлтийг хэлэлцэхэд үнэт цаас гаргагч, тухайн үнэт цаас гаргах ажиллагаатай холбогдуулан аудит, үнэлгээ, хуульчийн дүгнэлт гаргасан, мэргэжлийн зуучлах үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын төлөөллийг Хорооны хуралдаанд оролцуулж, зохих тайлбар өгөх боломж олгоно. Тэд Хорооны хуралдаанд ирээгүй нь асуудлыг хойшлуулах үндэслэл болохгүй.

3.14. Хороо дараахь үндэслэлээр үнэт цаасыг бүртгэхээс татгалзана:

3.14.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.10.1-7.10.3-т заасан үндэслэл тогтоогдсон;

3.14.2. үнэт цаас гаргагч энэ журмаар тогтоосон шаардлагыг хангахгүй байгаа;

3.14.3. үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг хуурамч мэдээлэл агуулсан нь тогтоогдсон.

3.15. Үнэт цаасыг бүртгэхээс татгалзах шийдвэр гаргасан үндэслэл нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн байгууллагын буруутай ажиллагаанаас шалтгаалсан нь тогтоогдвол энэ нь тухайн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл болно.

3.16. Хороонд бүртгэсэн үнэт цаасны танилцуулгыг дараахь байдлаар баталгаажуулна:

3.16.1. Товч танилцуулгад Хорооны шийдвэртэй холбоотой мэдээллийг бүрэн тусгана;

3.16.2. Тухайн үнэт цаасны 3 хувь танилцуулга, түүнд хавсаргасан бүх бичиг баримтын хуудас бүрийн зүүн дээд өнцөгт “Санхүүгийн зохицуулах хороо бүртгэв” гэсэн тэмдэг дарж, огноог тэмдэглэнэ.

3.17. Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг Хороонд бүртгэж, танилцуулгыг баталгаажуулсны дараа үнэт цаасыг нийтэд санал болгох үйл ажиллагааг эхлүүлнэ.

**ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОХ, ҮНЭТ ЦААСНЫ  
ЗАХИАЛГА АВАХ, ҮНЭТ ЦААСНЫ ҮНИЙГ ТОГТООХ, ҮНЭТ ЦААСНЫ  
ХУВААРИЛАЛТ ХИЙХ, ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДАХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХУДАЛДАХ**

4.1. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүрэн болон товч танилцуулгад тусгасан мэдээллийг Хорооны зөвшөөрөлгүйгээр өөрчлөх, хасах, нэмэх болон уг танилцуулгад заагдсан мэдээллийг нийтэд мэдээлэхгүй байх, дутуу мэдээлэх, сонирхсон иргэн, хуулийн этгээдэд танилцуулахаас татгалзах, цаараглах, тухайн үнэт цаасны үнийн өсөлтийн талаар таамаглал, амлалт, магадлал бүхий мэдээллийг нийтэд цацах, тухайн үнэт цаасны үнийг гадаад дотоодын үнэт цаас гаргагч бусад этгээдийн үнэт цаасны үнийн өөрчлөлттэй харьцуулсан болон аливаа төөрөгдүүлсэн мэдээллийг нийтэд түгээхийг хориглоно.

4.2. Үнэт цаасыг нийтэд санал болгоход дараах бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн байна:

- 4.2.1. Үнэт цаасыг нийтэд санал болгох ажлыг зохион байгуулахад шаардлагатай хөрөнгийг хуримтлуулсан байна;
- 4.2.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх болон Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагад үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлтээ гаргана. Шаардлагатай бол үнэт цаасны захиалга авах талаар тусгайлан гэрээ байгуулна;
- 4.2.3. Үнэт цаасыг хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны хэрэгслээр хүргэх бэлтгэлийг хангана.
- 4.2.4. Үнэт цаасны танилцуулгын электрон хувилбарыг бэлтгэж Хороо, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага, зуучлагчаар оролцож буй мэргэжлийн байгууллагын болон өөрийн компанийн веб хуудсанд байршуулна.
- 4.2.5. Үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулгатай хүссэн этгээд танилцах ажлын байрыг бэлтгэсэн байна;

4.3. Үнэт цаасны танилцуулгыг үнэт цаас гаргагч болон андеррайтер нь дараахь арга, хэлбэр, давтамжтайгаар нийтэд танилцуулна:

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

- 4.3.1. 3-аас доошгүй хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны товч танилцуулгыг нийтэд хүргүүлэх, байршуулах;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

- 4.3.2. Үнэт цаасыг нийтэд санал болгож эхэлсэн өдрөөс хойш ажлын 2-оос доошгүй хоногийн дотор нийтэд хандаж хэвлэлийн бага хурал хийх;
- 4.3.3. Телевиз, радиогоор нийтэд мэдээлэл хүргэх;
- 4.3.4. Товч танилцуулгыг 500-гаас доошгүй хувь хэвлүүлж, компанийн ажлын байр, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, захиалга хүлээн авах бокер дилерийн компанийн ажлын байранд хүрэлцэхүйц тоогоор байршуулах;
- 4.3.5. Үнэт цаас гаргагч нь танилцуулах аялал, уулзалт зохион байгуулах замаар /road show/ танилцуулга хийх бол оролцогчдод товч танилцуулгыг хэвлэж тараана.

4.4. Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь Хороонд бүртгэгдсэн үнэт цаасны танилцуулгад заасан арга хэлбэрээр тухайн үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулна. Андеррайтер болон хэд хэдэн андеррайтер хамтран ажиллахаар байгуулсан гэрээгээр үнэт цаасыг хатуу нөхцөлөөр бүгдийг эсхүл хэсгийг нь худалдан авахаар тохирч, үнэт цаас гаргагчид үнийг төлсөн бол үнэ нь төлөгдсөн хувьцааг андеррайтерийн компанийн нэр дээр шилжүүлэн бүртгэнэ. Ингэхдээ андеррайтераас үнэт цаас гаргагчид хувьцааны үнийг шилжүүлснийг нотлох баримт, үнэт цаас гаргагчийн хүсэлтийг үндэслэл болгоно.

4.5. Үнэт цаасыг андеррайтерууд бүхэлд нь худалдан аваагүй бол дараах 3 аргын аль нэгээр нь юмуу эсхүл хосолсон арга хэлбэрээр анхдагч зах зээлд байршуулна.

4.5.1. Тогтоосон үнээр санал болгон байршуулах;

4.5.2. Үнэ хаялцуулан дуудлагаар худалдах;

4.5.3. Үнэт цаасны товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг хэвлэл мэдээллийн болон зар сурталчилгааны арга хэрэгслээр нийтэд хүргэх бэлтгэл хангасан байх.

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

4.6. Тогтоосон үнээр санал болгон байршуулах бол арилжаа эрхлэх байгууллагатай гэрээ байгуулан арилжаа эхлэх өдрийг тогтоож, Хорооноос зөвшөөрөл авсан байна.

4.7. Захиалга авч эхлэх өдрөөс ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө үнэт цаасны тухай ерөнхий мэдээлэл, худалдахаар санал болгож байгаа үнэ, арилжаалж эхлэх, дуусах өдөр, цагийн тухай мэдээллийг олон нийтэд болон үнэт цаасны арилжаанд оролцох эрхтэй БД-ийн бүх компанид хүргэсэн байна.

4.8. Тогтоосон үнээр санал болгон арилжихад үнэт цаасыг нийтэд санал болгон сурталчилж эхэлсэн өдрөөс хойш ажлын 10-аас доошгүй хоногийн дараа худалдан авах захиалгыг авч эхэлнэ. Энэ аргаар анхдагч зах зээлийн арилжаа явуулахад захиалсан үнийн хамгийн өндрөөс эхлэн захиалгыг биелүүлнэ. Үнийн санал тэнцсэн тохиолдолд захиалсан цаг хугацааны дэс дарааллыг баримтлан арилжаа явуулна. Арилжаа үргэлжлэх хугацаа нь 1 сараас илүүгүй байна.

4.9. Арилжаа эрхлэх байгууллага тогтоосон үнээр анхдагч зах зээлийн арилжаа явуулах журам боловсруулж, Хорооны саналыг тусган баталж мөрдүүлнэ. Уг журамд анхдагч зах зээлийн арилжааг хоёрдох зах зээлийн арилжаанаас тусгайд нь явуулах асуудлыг тусгасан байна.

4.10. Үнэт цаасыг бүхэлд нь юмуу зарим хэсгийг анхдагч зах зээлд багцлан худалдахаар танилцуулгад тусгасан бол үнэ хаялцуулан дуудлагаар худалдах аргыг сонгож болно. Энэ аргаар анхдагч зах зээлд байршуулахдаа арилжаа эрхлэх байгууллагатай гэрээ байгуулан Хорооноос зөвшөөрөл авч дуудлага худалдаа явуулж эхлэх өдөр, цагийг тогтоон, арилжаа эрхлэх байгууллагын сүлжээг ашиглан зохион байгуулна. Дуудлагаар худалдах багц бүрийг бүрдүүлж байгаа үнэт цаасны тоо, дуудах хамгийн доод үнийн санал, дуудлагын худалдаа эхлэх, дуусах хугацааны тухай мэдээллийг үнэт цаасны танилцуулгын хамт брокер дилерийн бүх компанид дуудлагын худалдаа эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлж, олон нийтэд мэдээлэл хүргэсэн байна. Дуудлагын худалдааны үргэлжлэх хугацаа нь 21 хоногоос илүүгүй байна.

4.11. Арилжаа эрхлэх байгууллага дуудлагын худалдаа явуулах журмын төсөл боловсруулж, Хорооны саналыг тусган баталж мөрдүүлнэ. Үүнд дуудлагаар худалдах багцыг худалдан авах санал сүлжээнд байрлаж байх доод хугацааг тусгасан байна.

4.12. Захиалгын бүртгэл хийх аргаар анхдагч зах зээлд байршуулах бол захиалгыг тухайн үнэт цаасыг нийтэд танилцуулж эхэлснээс хойш ажлын 6 хоногоос доошгүй хугацааны дараа авч эхлэх бөгөөд үргэлжлэх хугацаа нь 1 сараас илүүгүй байна.

4.13. Үнэт цаас гаргагч болон андеррайтер нар нь харилцан тохиролцож, санал болгох үнийн дээд доод хязгаарыг тогтоосон байхаас гадна арилжаа эрхлэх болон төлбөр тооцооны байгууллагатай тохиролцон захиалгын бүртгэл эхлэх дуусах хугацааг тогтоож, захиалгын бүртгэл эхлэхээс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө брокер дилерийн компаниудад хүргүүлж, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр нийт 10-аас доошгүй удаа зарласан байна.

4.14. Тухайн үнэт цаасыг худалдан авахыг сонирхогч этгээд нь захиалгыг бүртгэх хугацаанд тодорхой үнээр, тодорхой тооны үнэт цаас худалдан авахаар захиалга өгч болохоос гадна, үнэ, тоо заалгүй худалдан авах нийт үнийн дүнгийн хэмжээг зааж өгч болно. Нийт үнийн дүнгийн хэмжээг заасан захиалгыг анхдагч зах зээлд байршуулах үнэ ямраар ч тогтсон байршуулсан үнийн дүндээ тохирсон тооны үнэт цаас худалдан авна гэсэн хүсэл зоригийн илэрхийлэл гэж ойлгоно.

4.15. Захиалгыг брокер дилерийн компаниар дамжуулан хүлээн авах бөгөөд хүлээн авсан захиалгыг өдөр бүр арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон цагт арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны ердийн арилжааны захиалгыг арилжааны програмд бүртгэн авдагтай нэгэн адилаар бүртгэнэ. Бүртгэгдсэн захиалгыг баталгаажуулах зорилгоор захиалга өгөхдөө барьцаа хөрөнгийг /захиалгын үнийн дүнгийн 30-аас доошгүй хувиар/ төвлөрсөн хадгаламжийн дансандаа байршуулах бөгөөд захиалга хаахаас 24 цагийн өмнө захиалга хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг бүрэн байршуулсан байна.

4.16. Захиалсан үнэт цаасны төлбөрт зориулсан барьцаа хөрөнгийг арилжаа хийгдэх хүртэл тусгаарлах арга хэмжээ авна.

4.17. Захиалгын маягыг бүрэн бөглөж, худалдан авах үнэт цаасны төлбөрийг үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан бөгөөд арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд орсон захиалгыг хүчин төгөлдөр болсонд тооцно.

4.18. Үнэт цаасны захиалга авах хугацаа дуусах өдрийн ажлын цаг дууссанаас хойш нэмж захиалга авахыг хориглоно.

4.19. Үнэт цаасны захиалга авах хугацаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан үнэт цаасны худалдах үнийг тогтоож, биелэх боломжтой захиалга тус бүрээр үнэт цаасны хуваарилалтыг хийнэ. Энэ үед захиалга өгсөн этгээдийн дансанд үнэт цаасыг байршуулахгүй бөгөөд урьдчилсан байдлаар тухайн захиалагчид ногдох хувьцааны тоо ширхэгийг тогтооно.

4.20. Үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдах үнийг андеррайтер, үнэт цаас гаргагч нар хамтран тогтооно. Уг үнийг тогтоохдоо тухайн үнэт цаасыг худалдан авахаар ирүүлсэн нийт захиалгын жигнэсэн дундаж үнэ, үнэт цаасны борлуулалтаас олохоор төлөвлөсөн хөрөнгийг бүрэн бүрдүүлэх боломжит үнэ, аль болох олон этгээдийн захиалгыг биелүүлэх боломжит үнэ зэргийг харгалзана.

Үнийг тогтоосны дараа тогтсон үнэ болон түүнээс дээгүүр үнээр захиалга өгсөн этгээдэд захиалга өгсөн цаг хугацааны дарааллаас үл хамаарч<sup>1</sup> захиалсан хувьцааны тоонд хувь тэнцүүлэн хуваарилна.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.21. Хувьцаат компани нэмж хувьцаа гаргаж байгаа тохиолдолд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэхээр захиалга өгч, компанийн ТУЗ-өөс тогтоож, Хороонд бүртгэгдсэн үнээр тооцон төлбөрийг төлсөн, Компанийн тухай хуулийн 38 дүгээр зүйлд заасны

---

<sup>1</sup> Энэхүү хугацааг захиалга авахаар нийтэд зарласан хугацааны дотор ирсэн захиалгын цаг хугацааны дарааллаас ил хамаарахаар ойлгоно. Уг хугацаанд захиалга авахаар нийтэд зарласан хугацаанаас тэрийлж, эсхил хоцорч ирүүлсэн захиалгыг тооцохгүй.

дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд ногдох үнэт цаасыг эхлэн хуваарилна.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.22. Үнэт цаасны танилцуулгад стратегийн хөрөнгө оруулагчдад тодорхой хэмжээний хувьцааг тохирсон үнээр худалдахаар заасан бөгөөд энэ журмын 4.21-д заасан хуваарилалтыг хийх шаардлагатай бол энэ хуваарилалтыг хийсний дараа танилцуулгад заасан хэмжээгээр стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилалт хийнэ. Үлдсэн үнэт цаасыг танилцуулгад заасан арга хэлбэрээр анхдагч зах зээлд байршуулна.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.23. Хуваарилагдаагүй үлдсэн хувьцааг зарласан боловч эргэлтэд гаргаагүй хувьцаа гэж тооцон бүртгэнэ.

4.24. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах ажиллагаа дууссаны дараа Хорооны зөвшөөрлөөр тухайн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаас гаргагч нь уг зөвшөөрлийг авахдаа дараахь шаардлагыг хангасан байна:

4.24.1. Нийтэд санал болгосон үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдан, байршуулсан тухай тайлан, ирсэн нийт захиалга, нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө, хувьцааны захиалга авах аргаар анхдагч зах зээлд байршуулсан бол үнэт цаасны үнийг тогтоосон үндэслэл тооцоо, үнэт цаасны хуваарилалт, биелээгүй захиалгын жагсаалт;

4.24.2. Нэмж гаргасан хувьцааг давуу эрхээр худалдан авч байгаа болон стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилсан хувьцааны жагсаалт, үндэслэл, тооцоо.

4.25. Энэхүү журамд заасны дагуу тогтоосон үнээр болон үнэ хаялцуулан дуудлагаар худалдах аргаар арилжаа явуулсан бол арилжаа явуулахаар тогтоосон хугацаанд борлуулсан хувьцааны үнийн дүн нь, захиалгын бүртгэл хийх аргаар үнэт цаасны хуваарилалтыг хийсэн боловч биелүүлэх боломж бүхий захиалгын үнийн дүн нь үнэт цаасны борлуулалтаас олохоор тооцсон хөрөнгийн 70 –аас доошгүй хувийг бүрдүүлж чадаагүй тохиолдолд анхдагч зах зээлийн арилжааг явуулах хугацаа дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааг амжилтгүй болсонд тооцож, Хороо үнэт цаасыг бүртгэх тухай шийдвэрээ хүчингүй болгож нийтэд зарлана.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.25<sup>1</sup>“Үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээ, улс орны хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжтой зэрэг эдийн засгийн ач холбогдлыг харгалзан Хороо энэ журмын 4.25-д заасан хэмжээнээс өөрөөр тогтоож болно”;

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор нэмсэн/*

4.26. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа дуусах хүртэл хугацаанд борлуулалтын орлогыг үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй төвлөрсөн хадгаламжид хадгална.

4.27. Анхдагч зах зээлийн арилжаа амжилтгүй болсон тохиолдолд төвлөрсөн хөрөнгийг үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага захиалга өгсөн иргэн, хуулийн этгээдэд буцаан олгоно.

4.28. Хороо нь холбогдох баримтыг хүлээн авч дор дурдсан шаардлагыг хангасан гэж үзвэл захиалга авах аргаар хийж буй үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа хийх зөвшөөрлийг үнэт



цаас гаргагчид олгох ба уг арилжааг зөвшөөрөл өгснөөс хойш ажлын 2 хоногт багтаан гүйцэтгэнэ:

4.28.1. Анхдагч зах зээлийн үнийг үндэслэлтэй тогтоож, уг үнээр болон түүнээс дээш үнээр захиалга өгсөн бүх этгээдийн захиалга биелэх боломжтой болсон;

4.28.2. Энэ журамд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар борлуулалтаас олохоор тооцсон хөрөнгийн 70-аас дээш хувийг төвлөрүүлж, орлого нь үнэт цаас гаргагчид шилжих боломжтой болсон;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.28.2<sup>1</sup>. Үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээ, улс орны хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжтой зэрэг эдийн засгийн ач холбогдлыг харгалзан Хороо энэ журмын 4.28.2-д заасан хэмжээнээс өөрөөр тогтоож болно”;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор нэмсэн/*

4.28.3. Тухайн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх бэлтгэл хангагдсан;

4.28.4. Анхдагч зах зээлд үнэт цаасыг байршуулах асуудлаар үндэслэлтэй гомдол гараагүй.

4.29. Анх удаа хувьцаагаа нийтэд санал болгож байгаа компани хувьцааныхаа багцыг стратегийн хөрөнгө оруулагчдад худалдахаас өөрөөр хаалттай захиалгаар худалдахыг хориглоно. Харин хаалттай компани байх үеийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг нээлттэй компанийн хувьцаанд дор заасан журмын дагуу шилжүүлснийг хаалттай захиалга гэж үзэхгүй.

4.29.1. Нээлттэй компани болон өөрчлөгдөж байгаа хаалттай компанийн аудитийн байгууллагаар баталгаажуулж, андеррайтер хянан зөвшөөрсөн сүүлчийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр хөрөнгийн дүнг хувьцааны нэрлэсэн үнэд хуваасантай тэнцэх тооноос илүүгүй тооны хувьцааг хөрвүүлнэ. Хаалттай компанийн хувь нийлүүлэгч бүр хэдэн ширхэг хувьцааг хөрвүүлж эзэмшихийг компанийг өөрчлөн байгуулах төсөлд заасан байна.

4.29.2. Өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайланг гаргахын өмнө хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж үнэлгээний дүнг санхүүгийн тайланд тусгасан байж болно. Компанийн өөрийн бий болгосон бөгөөд Оюуны өмчийн газарт бүртгэгдсэн биет бус хөрөнгийг бий болгосон өртгөөр нь үнэлсэн байна. Дахин үнэлгээгээр биет бус хөрөнгийг нэмэгдүүлэн үнэлэхийг хориглоно. Харин худалдан авсан биет бус хөрөнгийг худалдан авсан үнээр нь үнэлж, бүртгэл, тайланд тусгасан байна.

4.30. Хаалттай захиалгаар худалдахаар хувьцаа нэмж гаргаж байгаа бол худалдах үнийг тухайн хувьцааны сүүлийн 6 сарын арилжааны жигнэсэн дундаж ханш, компанийн хувьцааны дансны үнэ зэрэгт үндэслэн тогтоосон байх бөгөөд эдгээр үнийн дунджаас доогуур үнээр тогтоохоор Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэсэн бол Компанийн тухай хуулийн 38 дүгээр зүйлд заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хувьцаа эзэмшигчиддээ олгохоор шийдвэрлэсэн байх ёстой.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

4.31. Хаалттай захиалгаар хувьцаа худалдан авч байгаа этгээд нь хувьцаа худалдан авахад шаардагдах мөнгийг үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн байгууллагад байршуулсан юмуу компанид шилжүүлснийг нотлох банкны байгууллагын тодорхойлолт,

нягтлан бодох бүртгэлийн үндсэн баримт зэргийг Хороонд ирүүлснийг үндэслэн өмчлөх эрхийг баталгаажуулах тухай шийдвэр гаргана.

4.32. Өрийг хувьцаагаар солихоор нэмж хувьцаа гаргаж байгаа юмуу зарласан боловч гаргаагүй хувьцаанаас өрийг сольж эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн бол өр үүссэн тухай болон өр нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгагдсаныг нотлох үндсэн баримт, аудитийн байгууллагын тодорхойлолтыг Хороонд ирүүлснийг үндэслэн өрийг сольсон хувьцааны өмчлөх эрхийг баталгаажуулах зөвшөөрөл олгоно. Өрийг сольж байгаа хувьцааны үнийг энэхүү журмын 4.30-д заасны дагуу тодорхойлно.

4.33. Ногдол ашигт олгохоор хувьцаа нэмж гаргаж байгаа бол хувьцааг бүртгэх тухай Хорооны шийдвэр гарсны дараа хувьцаа эзэмшигч бүрийн дансанд нэмж олгох хувьцааг бүртгэхээр арилжааг түр зогсоох бөгөөд ажлын 5 хоногийн хугацаанд үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага энэ ажиллагааг хийж дуусгана.

4.34. Энэ журамд заасан стратегийн хөрөнгө оруулагч гэдгийг үнэт цаас гаргагчтай хамтран ажиллах гэрээ байгуулсан, нийт зарласан хувьцааны таваас доошгүй хувийг хөрөнгө оруулж эзэмшсэн, хувьцаагаа хоёрдогч зах зээлд Хорооноос тогтоосон тодорхой хугацаанд худалдахгүй байх үүрэг хүлээсэн иргэн, хуулийн этгээдийг ойлгох бөгөөд түүнийг тухай бүр Хорооноос тогтооно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор нэмсэн/*

## **ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭЛД ТУСГАХ, ТАЙЛАН ГАРГАХ, БАТАЛГААЖУУЛАХ**

5.1. Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн арилжаа хийгдэж дууссанаас хойш 10 хоногийн дотор үнэт цаасны гүйлгээний талаарх дэлгэрэнгүй тайланг 5 дугаар хавсралтаар гаргаж, Хороонд ирүүлнэ.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

5.2. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 5.1-д заасан хугацаанд багтааж үнэт цаасны гүйлгээний товч тайланг нийтэд мэдээлнэ. Хэрэв нээлттэй компани болон өөрчлөгдөж анх удаагаа хувьцаагаа нийтэд санал болгон худалдсан бол уг мэдээлэлд компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын товыг тусгасан байна.

5.3. Захиалга нь биелээгүй болон биелсэн боловч байршуулсан хөрөнгө нь илүүдэлтэй этгээдийн үлдэгдэл хөрөнгийг энэхүү журмын 5.1-д заасан хугацаанд буцааж шилжүүлэх ажиллагааг үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага гүйцэтгэж дуусгасан байна. Холбогдох этгээд цаашид үнэт цаасны арилжаанд оролцохоор мөнгөө дансандаа үлдээхийг хүсэж, “Мөнгө хүссэн өргөдөл”-өө ирүүлээгүй бол энэ хугацаа хамаарахгүй.

5.4. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны борлуулалтын орлогыг тусгай дансаар бүртгэх бөгөөд тодорхой төсөл хэрэгжүүлэхээр үнэт цаас гаргасан бол тухайн төслийн нэр дээр дэлгэрэнгүй бүртгэлийн данс нээж бүртгэнэ.

5.5. Төсөл хэрэгжүүлэхээр үнэт цаас гаргасан компани төсөл бүрэн хэрэгжиж дуусах хүртэл улирал бүр төслийн хэрэгжилтийн явцын тайлан, хөрөнгийн зарцуулалтын тайланг зардлын зүйл тус бүрээр гарган, нягтлан бодох бүртгэлийн улиралын тайлангийн хамт дараа улирлын эхний сарын 20-ний дотор Хороонд ирүүлэхээс гадна өөрийн сайтаар нийтэд мэдээлнэ.

5.6. Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлд байршуулах хугацаанд ирсэн захиалгыг архив, бичиг хэргийн хадгалалтын шаардлага, стандартын дагуу эмхэтгэн архивын нэгж болгон үнэт үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагын архивт хүлээлгэн өгнө.

## **ЗУРГАА. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ, АНДЕРРАЙТЕР, ХУУЛЬЧ, ҮНЭЛГЭЭЧИН, АУДИТОРЫН ХАРИУЦЛАГА**

6.1. Үнэт цаас гаргагч нь андеррайтер, хуульч, үнэлгээчин, аудиторт энэ журамд заасан ажиллагааг хэрэгжүүлж, дүгнэлт гаргахад шаардлагатай бодитой мэдээллийг бүрэн гаргаж өгнө. Гаргаж өгсөн мэдээлэл нь дутуу, бодит байдалтай нийцээгүй, төөрөгдүүлсэн мэдээлэл байснаас хөрөнгө оруулагчдад учруулсан хохирлыг үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан хариуцна.

6.2. Хуульч, үнэлгээчин, аудитор, андеррайтер нь үнэт цаас гаргагчаас өгсөн баримтад тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд дүгнэлт гаргасан байна. Тэдгээрийн гаргасан дүгнэлт бодит байдалд нийцээгүйгээс хөрөнгө оруулагчдад учирсан хохирлыг хариуцна.

6.3. Гаргасан дүгнэлт буруу байснаас хөрөнгө оруулагчдад хохирол учруулсан нь тухайн этгээдийг Хороо цаашид хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл болно.

6.4. Андеррайтер нь үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулахын өмнө урдьчилан нарийвчилсан судлагаа хийж, бүх талын дүгнэлт хийх боломжтой, компанийн бизнесийн үнэлгээг хийх эрх бүхий 2-оос доошгүй үнэлгээчинтэй, эсхүл эрх бүхий үнэлгээчинтэй гэрээ байгуулах боломжтой тохиолдолд гэрээ байгуулна.

6.5. Андеррайтер нь бусад андеррайтерийн компанитай гэрээ байгуулан синдикат хэлбэрээр ажиллахаар шийдвэрлэсэн бол байгуулах гэрээний төслийг ирүүлсэн байна. Гэрээнд оролцогч андеррайтер бүрийн хүлээх үүрэг, хариуцлага, андеррайтерийн үйл ажиллаганы хөлс төлбөрийг хэрхэн хуваах талаар тусгасан байна.

6.6. Үнэт цаасыг анхдагч зах зээлд ямар хэлбэрээр байршуулахаа үнэт цаас гаргагч андеррайтер нар хамтран тодорхойлно. Үнэт цаасны танилцуулгад ямар хэлбэрээр байршуулах тухай болон уг хэлбэрийг сонгосон шалтгаанаа тайлбарласан байна.

6.7. Андеррайтер хийсэн үнэт цаасных нь анхдагч зах зээлийн арилжаа 3 удаа амжилтгүй болсон нь андеррайтерийн тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болно.

## **ДОЛОО. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

7.1. Нэгдэх, нийлэх, хуваах хэлбэрээр хувьцаат компанийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, нэмж үнэт цаас гаргах, хувьцааг хуваах, нэгтгэх, нийтэд санал болгон гаргасан компанийн бондын арилжаалагдаагүй үлдэгдлийг хүчингүй болгох зэрэг тохиолдолд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулна.

7.2. Компанийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, үнэт цаас нэмж гаргах, хуваах, нэгтгэх тухай асуудлыг тухайн компани хувь нийлүүлэгчдийн хурлаар, бондын үлдэгдлийг

хүчингүй болгох асуудлыг анх бонд гаргах асуудлыг шийдвэрлэсэн эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэж шийдвэр гаргасан байна.

7.3. Тухайн компани энэхүү журмын 7.2-т заасан шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтээ, холбогдох шийдвэр, баримт бичгийн бүрдлийн хамт Хороонд ирүүлнэ.

7.4. Компани нийлэх, нэгдэх, хуваагдах болон үнэт цаасыг хуваах, нэгтгэх ажлыг төслийн үндсэн дээр гүйцэтгэх бөгөөд уг төслийг тухайн компанийн ТУЗ боловсруулж, хувь нийлүүлэгчдийн хурлаар батлуулсан байх ба төсөлд дараахь зүйлийг заавал тусгасан байна:

- 7.4.1. Компани нийлэх, нэгдэх, хуваагдах болон үнэт цаасыг хуваах, нэгтгэх нөхцөл, уг ажиллагааг гүйцэтгэх журам;
- 7.4.2. Өөрчлөн байгуулагдаж буй компанийн хувьцааг өөрчлөлтөөр бий болж буй компанийн хувьцаанд хөрвүүлэх харьцаа, холбогдох тооцоолол;
- 7.4.3. Өөрчлөн байгуулалтаар бий болж байгаа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ, өр төлбөр, эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, эрх, үүрэг хэрхэн шилжүүлэх тухай мэдэгдэл;
- 7.4.4. Компани өөрчлөн байгуулагдахтай холбоотой үүсэх хувь нийлүүлэгчдийн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөө, журам;
- 7.4.5. Хувьцаат компани нийлэх, нэгдэх, хуваагдах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болон өөрчлөн байгуулагдаж байгаа тохиолдолд тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн авах, хувьцааг хувааж, нэгтгэж байгаа тохиолдолд хувьцааны бутархай үлдэгдлийг худалдан авах үнийг тогтоосон байна.

7.5. Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авах үнийг тогтоохдоо Компанийн тухай хуулийн 55-т заасны дагуу хөндлөнгийн үнэлгээний байгууллагаас гаргасан дүгнэлтийг үндэслэх ба хэрэв уг үнийг нь үнэлгээ хийхийн өмнөх сүүлийн 6 сарын Хөрөнгийн бирж дээрх арилжааны дундаж ханшаас доогуур тогтоосон бол үнэлгээний байгууллага болон ТУЗ-өөс үнийг хэрхэн тогтоосон тухай тайлбар, нотлох баримтыг Хороонд ирүүлнэ.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

7.6. Хувьцааг хуваах, нэгтгэх төсөлд хувьцааны бутархай үлдэгдлийг компани ТУЗ-өөс тогтоосон үнээр худалдан авах, хувьцаа эзэмшигч хүсвэл зөрүүг мөн үнээр тооцож компанид төлснөөр бүхэл хувьцаа эзэмших эрхтэй байхаар заасан байна.

7.7. Өөрчлөн байгуулах төслийг хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэдэг журмаар хувь нийлүүлэгчдэд хүргэж саналыг авах арга хэмжээ авсан байна.

7.8. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ:

- 7.8.1. Компанийн тухай хуулийн 65.4-т заасан асуудлыг бүрэн тусгасан хувь нийлүүлэгчдийн хурлын тов, уг товыг хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу хүргэсэн тухай мэдээлэл;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

- 7.8.2. Санал хураалтын дүнг баталсан тооллогын комиссын тогтоол;
- 7.8.3. Компанийг өөрчлөн байгуулах болон хувьцааг хуваах, нэгтгэх төсөл;

- 7.8.4. Компани өөрчлөн байгуулагдсантай холбогдон хувь нийлүүлэгчдээс хувьцааг нь эргүүлэн худалдан авах болон хувьцааг, хуваасан, нэгтгэсний дараа үлдэх бутархай үлдэгдлийг худалдан авах үнэ, уг ажиллагааг зохион байгуулах журмыг баталсан ТУЗ-ийн шийдвэр;
- 7.8.5. Компанийг хуваах, өөр компанитай нийлүүлэх, нэгтгэх, хувьцааг хуваах болон нэгтгэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр болон энэ журмын 8.2-т заасан бусад мэдээлэл;
- 7.8.6. Компанийг өөрчлөн байгуулах комисс томилсон бол комиссын бүрэлдэхүүнийг баталсан шийдвэр, комиссын тайлан;
- 7.8.7. Хувьцаат компанийг хуваах болон өөр компанитай нийлүүлж шинээр байгуулагдсан компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэсэн бол энэ журмын 8.4, 8.6, 8.7-д заасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн тухай тайлбар, мэдээлэл;
- 7.8.8. Компанийн бондын арилжаалаагүй үлдэгдлийг бүртгэлээс хасуулах бол энэ тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, бүртгэлд өөрчлөлт оруулах болсон шалтгааны талаар тайлбар, бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн хугацаа болсон бол уг төлбөрийг хугацаанд барагдуулж байгаа тухай үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын тодорхойлолт;
- 7.8.9. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагаас тухайн компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахад татгалзах зүйлгүй, хамтран байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг тус тус бүрэн биелүүлсэн тухай тодорхойлолт;
- 7.8.10. Ногдол ашиг хуваарилсан байдал, хуваарилсан ногдол ашиг үлдэгдэлтэй бол уг хөрөнгийг үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага дахь холбогдох хувьцаа эзэмшигчийн нэрийн дансанд байршуулсан тухай баримт.
- 7.9. Хороо бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг хянаж үзээд энэ журмын 8.4, 8.6, 8.7-д заасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзвэл бүртгэлд өөрчлөлт оруулахаас татгалзаж болно.
- 7.10. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай Хорооны шийдвэр гарсны дараа ажлын 3 хоногт багтаан Ажлын алба үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд энэ тухай ажлын 10 хоногт багтаан улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

## **НАЙМ. ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ**

8.1. Хороонд бүртгэлтэй хувьцаат компани хязгаарлагдмал хариуцлагатай компани болж өөрчлөн байгуулагдах, эсхүл татан буугдах тохиолдолд тухайн компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасна.

8.2. Бүртгэлтэй хувьцаат компани хязгаарлагдмал хариуцлагатай компани болж өөрчлөн байгуулагдах, эсхүл татан буугдахаар хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр гарсан тохиолдолд бүртгэлээс хасуулах тухай хүсэлтийг тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор Хороонд гаргана. Уг хүсэлтийг дараахь баримт бичгийн хамт ирүүлнэ:

8.2.1. компанийг өөрчлөн зохион байгуулах тухай шийдвэр гаргасан хувь нийлүүлэгчдийн хурлын зар, тов, тэмдэглэл, хурлаас гаргасан шийдвэр, компанийг өөрчлөн зохион байгуулах төсөл, энэ талаар ТУЗ-өөс гаргасан шийдвэр;

8.2.2. компанийг өөрчлөн байгуулах төсөлд дараах зүйлийг тусгана:

8.2.2.1. компанийг өөрчлөн байгуулах болсон шалтгаан, зорилго;

8.2.2.2. өөрчлөх нөхцөл журам;

8.2.2.3. хувьцааг хөрвүүлэх арга, тооцоо;

8.2.2.4. Компанийн тухай хуульд зааснаар компанийг өөрчлөн зохион байгуулах асуудлаар эсрэг саналтай байсан болон саналаа өгөөгүй хувь нийлүүлэгчдээс хуульд заасны дагуу хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам.

8.2.3. компанийг өөрчлөн зохион байгуулах шийдвэрийн төслийг хувь нийлүүлэгчдэд урьдчилан хүргэсэн тухай тайлбар, баримт бичиг;

8.2.4. хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоох тухай ТУЗ-ийн шийдвэр;

8.2.5. дээрх үнийн талаар үнэлгээний байгууллагын дүгнэлт, уг үнэ нь энэхүү журмын 7.5-д заасан хэмжээнээс бага бол мөн хэсэгт заасан тайлбар;

8.2.6. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагаас тухайн компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахад татгалзах зүйлгүй бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргийг тус тус бүрэн биелүүлсэн тухай тодорхойлолт;

8.2.7. ногдол ашиг хуваарилсан байдал, хуваарилсан ногдол ашгийн өртэй бол уг хөрөнгийг үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага дахь хувьцаа эзэмшигчийн нэрийн дансанд байршуулсан баримт;

8.2.8. компанийн хяналтын багц хувьцааг нэгдмэл сонирхолтой эзэмшиж байгаа этгээд нь бусдынхаа хувьцааг худалдан авах саналаа гаргасан эсэх тухай мэдээлэл. Энэхүү саналыг гаргаагүй нь компанийн хувьцааг бүртгэлээс хасах шийдвэрийг хойшлуулах үндэслэл болно. Санал гаргаагүй боловч хувьцааг эргүүлэн авах үнэ нь хуулиар тогтоосны дагуу тодорхойлсон саналын үнээс дээгүүр бол санал заавал гаргасан байхыг шаардахгүй;

8.3. Хорооны ажлын алба энэ материалыг хянан үзээд хувь нийлүүлэгчдийн хурал нь хүчин төгөлдөр болоогүй, шийдвэр нь хууль бус, өөрчлөн байгуулах төсөлд хуульд заасан зүйлсийг бүрэн тусгаагүй, хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг үндэслэлгүй доогуур тогтоосон гэж үзвэл энэ журмын 8.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхийг хориглосон мэдэгдлийг компанид хүргүүлнэ. Уг мэдэгдэлд хориглож буй үндэслэлээ тайлбарласан байна.

8.4. Хорооноос өөрчлөн зохион байгуулах төсөлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн албан тоот явуулсан бол хувь нийлүүлэгчдийн хурлаас өөрчлөн зохион байгуулах ажлыг эрхлэн гүйцэтгэхээр томилсон комисс, томилоогүй бол компанийн гүйцэтгэх удирдлага Компанийн тухай хуулийн 54 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигч бүрт компанийг өөрчлөн байгуулах шийдвэр гарснаар хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрх үүссэн тухай болон эргүүлэн авахаар ТУЗ-өөс тогтоосон үнэ, эргүүлэн худалдахыг шаардах эрхээ хэрхэн хэрэгжүүлэх талаар бичгээр мэдэгдэл хүргүүлнэ.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

8.5. Хувьцаа эзэмшигчид энэхүү эрхээ хэрэгжүүлэх хугацаа нь мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 30 хоног байна. Мэдэгдэл нь алслагдсан аймаг, орон нутагт оршин сууж байгаа хувьцаа эзэмшигчдэд хүрэх, хариу ирүүлэх зэрэг хугацааг харгалзан мэдэгдэл явуулснаас хойш 2 сараас доошгүй байхаар тооцож саналыг хаах хугацааг тогтооно.

8.6. Хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн шаардлагын дагуу хувьцааны үнийг компанийн кассаас бэлэн мөнгөөр эсхүл харилцан тохиролцсоны дагуу эд хөрөнгийн хэлбэрээр олгосон, банкин дахь дансанд нь шилжүүлсэн, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг брокер, дилерийн компаниар дамжуулан олгосон зэргийг нотлох баримтад тулгуурлан хувьцааг нь эргүүлэн худалдан авсанд тооцно.

8.7. Дурдсан хугацаанд хариу ирүүлээгүй хувьцаа эзэмшигчийг хаалттай компанийн хувь нийлүүлэгчээр үлдсэнд тооцно. Хувьцаа эзэмшигч нь мэдэгдэл явуулсан хаяг байршилдаа байгаагүй, мэдэгдэл хоцорч очсон, хариу нь заасан хугацаанд ирж амжаагүй байж болзошгүй зэрэг нөхцөлийг харгалзан тэдний хувьцааг худалдан авахад шаардагдах мөнгөн хөрөнгийг үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага дахь дансанд нь, хэрэв дансаа нээгээгүй бол дансыг нь нээж байршуулна.

8.8. Хувьцаа эзэмшигч өөрөө биеэр ирж, хаалттай компанийн хувь нийлүүлэгчээр үлдэх саналаа гаргасан үед дээрх мөнгийг компанид эргүүлэн шилжүүлж, санал гаргасан этгээдийг компанийн хувь нийлүүлэгчээр бүртгэн авч, улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

8.9. Өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь хувь нийлүүлэгчдийн хувьцааг эргүүлэн худалдан авах үйл ажиллагааг брокер, дилерийн компанитай юмуу үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагатай гэрээ байгуулан, гэрээний дагуу хэрэгжүүлж болно.

8.10. Өөрчлөн зохион байгуулахаар шийдвэр гаргаж байгаа компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшиж буй эрх бүхий албан тушаалтан, тэдний нэгдмэл сонирхолтой этгээд нь Компанийн тухай хуулийн 57.1-д заасан үүргээ хэрэгжүүлж, бусдынхаа хувьцааг худалдан авах саналаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцүүлэн Хорооноос баталсан журмын дагуу зарласан, мөн Компанийн тухай хуулийн 54.4-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд хувь нийлүүлэгчид нь хувьцаагаа худалдан авахыг компаниас шаардах эрх үүссэн тухай мэдэгдэл хүргэж, хувьцаагаа эргүүлэн худалдаж авах ажиллагааг зохион байгуулсан байх шаардлагатай.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

8.11. Өөрчлөн зохион байгуулагдаж байгаа компани нь дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний дараа Хороонд үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлтээ ирүүлэх бөгөөд уг хүсэлтэд дараах материалыг хавсаргасан байна:

8.11.1. Хувьцааг эргүүлэн худалдан авахад шаардагдах мөнгийг үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагад шилжүүлсэн баримт, байгуулсан гэрээний хуулбар;

8.11.2. Энэхүү журмын 8.4, 8.6, 8.7, 8.9, 8.10-т заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн талаархи танилцуулга, холбогдох баримт материал.

8.12. Энэ журмын 8.17-д зааснаас бусад тохиолдолд компанийн үнэт цаасыг үнэт цаасны бүртгэлээс хасах тухай Хорооны шийдвэр гарсны дараагийн өдрөөс эхлэн тухайн компанийн үнэт цаасны арилжааг зогсооно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 278 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

8.13. Энэ журмын 8.4, 8.6, 8.7, 8.9, 8.10-т заасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзсэн тохиолдолд Хороо компанийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг түдгэлзүүлж болно. Энэ тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэлээ бичгээр мэдэгдэнэ.

8.14. Хороо өөрчлөн байгуулагдсан компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн албанд мэдэгдэнэ.

8.15. Хувьцаат компанийг татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан тохиолдолд татан буулгах комисс энэ тухай Хороонд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.

8.16. Компанийг татан буулгах шийдвэрийн тухай мэдэгдэлд дараах баримт бичгийг хавсарган ирүүлнэ:

- 8.16.1. татан буулгах тухай болон татан буулгах комисс томилсон тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;
- 8.16.2. татан буулгах хугацаа, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараагаар компанид үлдэж байгаа эд хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төсөл, уг төслийг баталсан хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;
- 8.16.3. компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах журам, хугацааг нийтэд мэдээлсэн тухай болон зээлдүүлэгчдэд бичгээр мэдээлсэн тухай баримт;
- 8.16.4. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагаас тухайн компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахад татгалзах зүйлгүй, хамтран байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг тус тус бүрэн биелүүлсэн тухай тодорхойлолт.

8.17. Компанийн татан буулгах шийдвэрийн дагуу үнэт цаасыг бүртгэлээс хасуулахаар ирүүлсэн хүсэлтийн дагуу үнэт цаасны бүртгэлээс хасах тухай Хорооны шийдвэр гарсны дараагийн өдрөөс эхлэн тухайн компанийн үнэт цаасны арилжааг зогсооно.

*/Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 278 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

8.18. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуулийн 27, 28, 29 дүгээр зүйлд заасан журмын дагуу татан буулгах ажиллагааг гүйцэтгэж дууссаны дараа компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсон тухай Хороонд мэдэгдэнэ. Уг мэдэгдэлд дараах бичиг баримтыг хавсаргасан байна:

- 8.18.1. татан буулгах түр болон дуусгалтын баланс;
- 8.18.2. компанийн эд хөрөнгийг худалдсан тохиолдолд уг хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэл байсан эсэх тухай тодорхойлолт, сонирхлын зөрчилтэй хэлцэл бол Компанийн тухай хуулийн 27.8-д заасны дагуу дуудлагын худалдаа явуулсан тухай мэдээлэл;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

- 8.18.3. компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан тайлан;
- 8.18.4. эзэмшиж буй хувьцаанд оногдох хөрөнгийг компаниас аваагүй хувьцаа эзэмшигчдэд оногдох мөнгийг үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар дамжуулан олгох тухай гэрээ, хувьцаанд оногдох мөнгийг шилжүүлсэн баримт;
- 8.18.5. ногдол ашиг хуваарилсан байдал, хуваарилсан ногдол ашиг үлдэгдэлтэй бол уг хөрөнгийг үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага дахь хувьцаа эзэмшигчийн нэрийн дансанд байршуулсан баримт.

8.19. Үнэт цаасны бүртгэлээс хасах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор Хороо олон нийтэд болон Улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.



---- ooOoo----

## НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн

\_\_\_\_\_ компанийн

/үнэт цаас гаргагчийн оноосон нэр/

\_\_\_\_\_ ... оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... тоот

/шийвэр гаргасан эрх бүхий байгууллагын нэр/

шийдвэрээр нийтэд санал болгон гаргахаар шийдвэрлэсэн доорх үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхээр энэхүү өргөдлийг гаргаж байна. /Холбогдох ... нүүр баримт бичгийг хавсарган хүргүүлэв/

Нэг. Үнэт цаас гаргагчийн:

Оноосон нэр, төрөл:	1.2. Улсын бүртгэлийн дугаар:	1.4. Регистрийн дугаар:
1.4. Үйл ажиллагааны чиглэл:	1.5. Оршин байх албан ёсны хаяг:	
1.6. Шуудангийн хаяг:	1.7. Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан ажиллах ажилтны овог нэр, албан тушаал:	
1.8. Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан ажиллах ажилтны холбоо барих ажлын утас:	1.9. Шуурхай холбогдох гар утас:	1.10. Цахим шуудангийн хаяг:

Хоёр. Гаргахаар шийдвэрлэсэн үнэт цаасны:

2.1. Үнэт цаасны нэр:	2.2. Үнэт цаасны төрөл:	2.3. Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ:
2.4. Үнэт цаасны тоо:	2.5. Үнэт цаасыг бусдад	2.6. Нийтэд санал болгох нэгж үнэт цаасны үнэ /нэрлэсэн үнээр санал болгох бол нэрлэсэн

	санал болгох хэлбэр:	үнэ, сонгох үнээр санал болгох бол дээд, доод үнэ/:
2.6. Үнэт цаасны нөхцөл /хямдруулсан, хөвөх, тогтмол хүүтэй, хугацаанаас нь өмнө эргүүлэн татах г.м./:		2.7. Үнэт цаасыг нийтэд санал болгох хугацаа:

Гурав. Үнэт цаасыг бүртгүүлэх, түүнийг анхдагч зах зээл дээр худалдах ажиллагаанд мэрэгжлийн байгууллага оролцож байгаа бол:

3.1. Оноосон нэр:	3.2. Улсын бүртгэлийн дугаар:	3.3. Регистрийн дугаар:
3.4. Оршин байх хаяг:	3.5. Шуудангийн хаяг:	3.6. Тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагааны төрөл:
3.7. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:		3.8. Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан ажиллах ажилтны овог нэр, албан тушаал:
3.9. Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан ажиллах ажилтны холбоо барих ажлын утас:	3.10. Шуурхай холбогдох гар утас:	3.11. Цахим шуудангийн хаяг:

Дөрөв. Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт \_\_\_\_\_

Тав. Үнэт цаасны зах зээлд зуучлах мэрэгжлийн байгууллагын гүйцэтгэх үйчилгээ, үнэт цаасныг анхдагч зах зээлд худалдан авах талаар байгуулсан гэрээ хэлцлийн талаарх мэдээлэл:

1. \_\_\_\_\_
2. \_\_\_\_\_
3. \_\_\_\_\_

Зургаа. Энэхүү өргөдөлд, түүнд хавсарган ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч ..... компани бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны танилцуулгад бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан: Овог, нэр:.....

Албан тушаал:.....

Гарын үсэг:.....

(Тухайн хуулийн этгээдийн тамга, тэмдэгийг дарсан байна.)

Өргөдөл гаргасан огноо:.....

**ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөнө/**

Өргөдөл хүлээн авсан ажилтаны овог нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:
---	---	---

## ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Танилцуулгын эхний хэсэг

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

Хаяг: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Факс: \_\_\_\_\_

Имайл: \_\_\_\_\_

2. Улсын бүртгэлийн тухай товч мэдээлэл:

3. Үнэт цаас гаргагчийн түүх, үйл ажиллагааны төрөл, хэтийн төлөв, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл, тухайн зах зээлд үнэт цаас гаргагчийн эзлэх байр суурийн талаархи мэдээлэл, судалгаа:

4. Үнэт цаас гаргагчийн зохион байгуулалт, удирдлагын бүтэц, салбар төлөөлөгчийн газрууд, нэгжийн тухай танилцуулга:

5. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас дээш хувийг эзэмшдэг этгээдийн талаарх мэдээлэл:

Нэр	Иргэн бол эрхэлдэг ажил, Хуулийн этгээд бол байршил	Эзэмшиж буй хувьцааны %

6. Эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл тэдгээр тухайн зомпанийн хувьцааг эзэмшдэг бол түүний хувь хэмжээ:

Овог нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны %

--	--	--	--

7. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл;
8. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрэмд тусгагдсан хувьцаа эзэмшигчийн эрх болон ногдол ашгийн бодлогын талаарх мэдээлэл;
9. Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах тухай үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагын шийдвэр. Хэрэв уг үнэт цаасыг гаргах нь тухайн компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохоор бол шийдвэрийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргасан тухай мэдээлэл;
10. Сүүлийн 3 жилийн болон үнэт цаасыг бүртгүүлэхээр зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахын өмнөх улиралын аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүд /2008 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 143 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар/;
11. Үнэт цаас гаргагч компани болон түүний толгой, охин компани болон хяналтын багцыг эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэл, тэдгээр нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй болох талаар банкны өр барагдуулах алба, харилцагч банкны тодорхойлолт байгаа тухай мэдээлэл;
12. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэсэн тухай мэдээлэл, бизнесийн үнэлгээний талаарх үнэлгээний байгууллагын дүгнэлт;
13. Тодорхой төсөл хэрэгжүүлэхээр үнэт цаас гаргаж байгаа бол түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл /тусгай зөвшөөрөл, газар эзэмших эрх, лицензи, патент зэрэг шаардлагатай бусад эрхүүд/ -ийн талаарх мэдээлэл.

### **Танилцуулгын хоёрдахь хэсэг**

1. Үнэт цаасны төрөл, хэлбэр;
2. Үнэт цаас эзэмшигчийн эрх;
3. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график;
4. Урьд нь үнэт цаас гаргаж байсан эсэх, гаргаж байсан бол үнэт цаасны нэр төрөл, гаргасан огноо, нийт хэмжээ, төлөгдөх буюу төлөгдсөн хэмжээ, өрийн бичиг гаргасан бол үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулж байсан тухай үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагын тодорхойлолт байгаа тухай мэдээлэл;
5. Үнэт цаас гаргах замаар хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах төслийн товч танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо;
6. Үнэт цаасыг санал болгох хүрээ;
7. Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ бүрэн байдлаар, энэхүү журмын 2.13-т заасан анхааруулга;
8. Үнэт цаасыг андеррайтераар дамжуулан анхдагч зах зээлд худалдахаар төлөвлөж байгаа бол уг байгууллагын тухай мэдээлэл;
9. Үнэт цаасны тухай мэдээлэл, дэлгэрэнгүй танилцуулгатай танилцаж болох газар, цаг, хариуцах ажилтны нэр, холбоо барих утасны дугаар.

## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАХ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА

### I. ЗАХИРЛУУД, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Энэ хэсэгт компанийн үнэт цаасыг бүртгүүлэх бичиг баримт, мэдээллийг бэлтгэхэд оролцсон хүмүүс болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтны тухай мэдээллээр хангахад оршино.

#### A. Захирлууд, эрх бүхий албан тушаалтан.

Тэдгээрийн нэр, эрхэлж буй албан тушаал болон чиг үүрэг.

#### B. Зөвлөхүүд.

Компанийн харилцдаг гол банк, удаан хугацаанд тогтвортой хамтран ажилласан хуулийн зөвлөх, үнэт цаасаа бүртгүүлэх ажиллагааг ивээн тэтгэгч болон бүртгүүлэх ажиллагаанд зөвлөлгөө өгсөн, дүгнэлт гаргасан хуулийн зөвлөх, аудитор, үнэлгээчин зэргийн нэр, хаяг.

B. Сүүлийн 3 жилд үйлчлүүлсэн аудитын байгууллага (тэдгээрийн харъяалах мэргэжлийн холбоо) –ын нэр, хаяг.

### II. САНАЛ БОЛГОХ АРГА ХЭЛБЭР

Энэ хэсэгт үнэт цаасыг санал болгох үйл ажиллагаатай холбоотой гол мэдээллүүд, мөн түүнчлэн санал болгох хугацааны талаарх мэдээллийг тусгана.

#### A. Санал болгох ажиллагааны тухай мэдээлэл

Санал болгох арга хэлбэр, гаргах үнэт цаасны нийт үнийн дүн. Үүнд: санал болгох үнэ, уг үнийг тодорхойлсон аргачлал ба гаргах хувьцааны тоо ширхэг зэрэг мэдээллийг тусгана.

#### B. Санал болгох арга хэлбэр, товлосон хугацаа.

Санал болгох үйл ажиллагаа, мөн түүнчлэн хөрөнгө оруулагчдын зорилтот бүлэг тус бүрээр нь санал болгох үйл явцад хамаарах дараах мэдээллийг танилцуулгад тусгасан байна.

1. Захиалга авах хугацаа, худалдан авах захиалгыг хаана, хэн хүлээн авах. Захиалгын хугацааг сунгах юмуу урьдчилан хааж болох эсэх, хэрэв тийм бол ямар хугацаагаар, үүнийг хэрхэн шийдвэрлэх, нийтэд хэрхэн хүргэх тухай мэдээлэл. Бүртгүүлэх хүсэлт гаргах үед захиалга авах хугацааг тодорхой тогтоох боломжгүй байгаа бол хэдийд хэрхэн тогтоож мэдээлэх тухай;

2. Үнэт цаасны төлбөр хийх арга хэлбэр, хугацаа; төлбөрийг хэсэгчлэн төлж болох бол бүрэн төлж дуусгах хугацаа;

3. Захиалагч, худалдан авагчдад хувьцааг хэдийд, хэрхэн шилжүүлэх. Үүнд: /гаргахаар тогтоосон бол өмчлөх эрхийн гэрчилгээг/

4. Тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй хувьцааны хувьд уг эрхийг хэрхэн хэрэгжүүлэх, уг эрхээ хэрэгжүүлэх захиалга өгөөгүй тохиолдолд захиалагдаагүй үлдсэн эрхийг хэрхэн шийдвэрлэх тухай мэдээлэл;

5. Үнэт цаасны хуваарилалтын дүнг олон нийтэд хэрхэн хүргэх, хэрэв илүү төлбөр хийгдсэн бол яаж буцаах, илүү төлөгдсөн хэсэгт хүү төлөх эсэх.

### **Ш. ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ**

Энэ хэсэгт компанийн санхүүгийн байдал, хөрөнгө, эрсдэлийн үзүүлэлтийн талаарх мэдээллүүдийг тусгана. Компанийн нэгдлийн бүтэц болон нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон томоохон өөрчлөлтүүдийг тусгах зорилгоор танилцуулгад тусгагдсан санхүүгийн тайланг шинэчлэсэн бол, санхүүгийн мэдээлэлд мөнхүү өөрчлөлтүүдийг тусган засварласан байх шаардлагатай.

#### **А.Түүвэрлэсэн санхүүгийн мэдээлэл.**

1. Сүүлийн 5 жилийн (үйл ажиллагаа явуулж эхлээд 5 жил хүрээгүй бол үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш) түүвэрлэсэн санхүүгийн түүхэн мэдээллийг санхүүгийн тайланг гаргасан мөнгөн нэгжээр гаргана. Дээр дурьдсан зорилгоор санхүүгийн тайланг шинэчлэсэн бөгөөд бусад санхүүгийн мэдээллийг ийнхүү шинэчлэх нь хэтэрхий их зардал, цаг хугацаа шаардахаар байгааг Зохицуулах байгууллагад мэдэгдсэн бол дээрх 5 жилийн эхний жилийн юмуу эхний 2 жилийн санхүүгийн мэдээллийг толилуулахгүй байж болно. Хэрэв аудитлагдаагүй улирлын санхүүгийн тайлангийн мэдээллийг оруулсан бол холбогдох санхүүгийн мэдээллийг мөн адил улирлаар гаргах ба аудитлагдаагүй гэдгийг тэмдэглэсэн байна. Түүвэрлэсэн санхүүгийн мэдээг улирлаар гаргасан бол жилийн тайлан тэнцэл нь харьцуулах тайлан тэнцэлийн шаардлагыг хангасан гэж үзсэнээс бусад тохиолдолд өмнөх жилийн мөн улиралтай харьцуулж болох мэдээллийг хамт гаргасан байна.

2. Түүвэрлэсэн санхүүгийн мэдээлэл нь компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдтэй адил ангилалаар тусгагдаагүй бол дараах зүйлүүдийг заавал тусгасан байна. Үүнд: цэвэр борлуулалт буюу үйл ажиллагааны орлого, нийт ашиг (алдагдал), цэвэр ашиг (алдагдал), нэгж хувьцаанд ногдох нийт болон цэвэр ашиг (алдагдал), нэгж хувьцаанд ногдох үндсэн үйл ажиллагааны болон үргэлжилж байгаа үйл ажиллагааны ашиг (алдагдал), нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө, хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө, хувьцаат капитал (урт хугацаатай өр төлбөр, эргүүлэн худалдан авахыг шаардах давуу эрх бүхий хувьцааг оруулахгүй), хөрөнгийн өөрчлөлтийг тусгасан хувьцааны тоо, нэгж хувьцааны зарласан ногдол ашгийг санхүүгийн тайланг гаргасан мөнгөн тэмдэгт болон үнэт цаас гаргаж буй орны мөнгөн тэмдэгтээр (зарласан ногдол ашигт ямар нэг байдлаар тохируулга хийх бол ашиглах томъёо орно) болон нэгж хувьцаанд ноогдох хорогдуулсан цэвэр ашиг зэрэг орно.

Нэгж хувьцаанд ногдох дүнгүүдийг тодорхойлохдоо санхүүгийн тайланг бэлдэхэд баримталсан нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтална.



3. VIII зүйлд шаардсаны дагуу санхүүгийн тайланг үнэт цаас гаргаж буй орны мөнгөн тэмдэгтээс өөр мөнгөн тэмдэгтээр бэлдсэн тохиолдолд үнэт цаас гаргаж буй орны мөнгөн тэмдэгтийг санхүүгийн тайланд ашигласан мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэх валютын ханшийг харуулна:

- а/ Боломжит хамгийн сүүлийн өдрөөр;
- б/ Сүүлийн 6 сарын сар бүрийн валютын хамгийн дээд, доод ханш
- в/ Сүүлийн 5 жил болон санхүүгийн тайлан гаргасан сүүлчийн улирлын дундаж, /тухайн хугацаанд хамаарах сар бүрийн эцсийн өдрийн ханшид үндэслэн тооцсон дундаж ханшаар тооцно/.

#### Б. Үнэлгээ тогтоох ба өр

Үнэлгээ болон өрийн тайлан (барьцаатай болон барьцаагүй, баталгаажсан болон баталгаажаагүй өрийн тусгайд нь харуулсан байна.)-д танилцуулах бичиг баримтыг хүргүүлсэн өдрөөс 60-аас илүүгүй өдрийн өмнөх байдлаарх мэдээллийг тусгах бөгөөд компанийн үнэлгээг бодит байдлаар нь тусгана. Боломжтой бол шинээр гаргаж буй үнэт цаасны борлуулалтаас олохоор төлөвлөж буй орлогын нөлөөллийг тусгах нь зүйтэй.

#### В. Нийтэд санал болгон үнэт цаас гаргаж буй шалтгаан, борлуулалтын орлогын зарцуулалт

1. Танилцуулгад үнэт цаасны борлуулалтаас олохоор төлөвлөж буй орлого, зарцуулалтын тооцоог тусгана. Төлөвлөж буй зарцуулалтыг зүйл бүрээр, дүнтэй нь харуулсан байна. Төлөвлөж буй зарцуулалтыг санхүүжүүлэхэд тооцоолсон орлого хүрэхээргүй бол зарцуулалтын зүйлийг ач холбогдлоор нь жагсааж, дутаж байгаа санхүүжилтийн эх үүсвэрийг хэрхэн олохоор төлөвлөж байгааг харуулсан байх хэрэгтэй. Хэрэв орлогыг зарцуулах тодорхой төлөвлөгөө байхгүй бол үнэт цаасыг нийтэд санал болгож буй үндсэн шалтгааныг бичнэ.

2. Бизнесийн ердийн үйл ажиллагаанд зориулагдсанаас өөр хөрөнгийг шууд болон шууд бусаар худалдан авахад үнэт цаасны борлуулалтын орлогыг ашиглах бол ямар хөрөнгийг ямар үнээр авахаар төлөвлөж байгаа мэдээлнэ. Хэрэв хөрөнгийг компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон холбогдох этгээдээс худалдан авах гэж байгаа бол хэнээс авч байгаа, үнийг нь хэрхэн тогтоох талаар мэдээлнэ.

3. Хэрэв орлого нь аливаа бизнесийг худалдан авахад зориулагдах бол тухайн бизнесийн талаар товч танилцуулах ба худалдан авах үйл ажиллагааны талаар мэдээллийг хүргэнэ.

4. Хэрэв орлогын ихээхэн хэсэг нь өр барагдуулахад зориулагдах бол тухайн өрийн хүү, хугацаа, түүнийг юунд зарцуулсныг мэдээлнэ.

#### Г. Эрсдэлийн үзүүлэлтүүд.

Энэ хэсэгт компанид болон түүний үйл ажиллагаа явуулж буй салбарт тохиолдож болох эрсдэлийн үзүүлэлтүүдийг эрсдэлийн нөлөөгөөр нь ангилан тусгана. Эдгээр үзүүлэлтэд, тухайлбал: тухайн компанийн эрхэлж буй болон эрхлэхээр төлөвлөж буй бизнесийн үйл ажиллагааны шинж чанар, үйл ажиллагаа явуулж буй тухайн улсын онцлог, хамгийн сүүлд алдагдал хүлээсэн ажиллагаа, компанийн санхүүгийн байдал, компанийн үнэт цаасны хөрвөх чадвар алдагдах магадлал, удирдлага хэр чадвартай, найдвартай, хувьцаа нэмж гаргаснаас хувьцаа эзэмшигчдийн хувь оролцоо буурч болох магадлал, хэвийн бус өрсөлдөөний нөхцөл, патент, гэрээ болон барааны тэмдэг зэргийн хугацаа дуусах, түр хүчингүй болох, мөн хэт цөөн тооны бэлтгэн нийлүүлэгч, үйлчлүүлэгчдээс хамааралтай байдал зэрэг мэдээллүүд орно.

## **IV. КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

Энэ хэсэгт үнэт цаас гаргагч компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, үзүүлдэг үйлчилгээ, компанийн бизнест нөлөөлөх хүчин зүйлүүдийн тухай мэдээлэл тусгана. Компанийн эд хөрөнгө, тоног төхөөрөмж нь тус компанийн үйл ажиллагаанд хэр нийцсэн, хангалттай эсэх, тэдгээрийн хүчин чадлыг ирээдүйд нэмэгдүүлэх, хорогдуулах төлөвлөгөөтэй эсэх талаар мэдээлнэ. Энэ хэсэгт тусгасан хөрөнгийг үнэлүүлсэн байна.

### **A. Компанийн түүх, цаашдын хөгжил**

Энэ хэсэгт дараах мэдээллийг тусгана:

1. Компанийн оноосон болон сурталчилгааны нэр.
2. Компани үүсгэн байгуулагдсан өдөр, хэрэв тодорхой бол компанийн үйл ажиллагаагаа явуулах хугацаа;
3. Компанийн оршин буй газар болон эрх зүйн хэлбэр, үйл ажиллагааны эрх зүйн орчин, үүсгэн байгуулагдсан газар, бүртгэгдсэн хаяг, утасны дугаар (эсвэл бүртгэгдсэн газраасаа өөр бол ерөнхий захиргаа байгаа хаяг) зэрэг мэдээлэл. Хэрэв компани нь үнэт цаас гаргаж буй орондоо төлөөлөгчтэй бол төлөөлөгчийн нэр, хаягыг бичнэ.
4. Компанийн түүхэнд гарсан чухал өөрчлөлтүүд. Жишээ нь: компани түүний охин компаниуд нэгдэх, нийлэх зэргээр өөрчлөн байгуулагдсан, энэхүү өөрчлөлтийн үр дүн, бизнесийн ердийн үйл ажиллагаанд зориулагдсанаас өөр томоохон хөрөнгө худалдан авсан, бусдад шилжүүлсэн, бизнесийн ердийн үйл ажиллагааг эрхлэн явуулах арга хэлбэр болон бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр төрөлд гарсан томоохон өөрчлөлт, оноосон нэрээ өөрчилсөн, дампуурал зарлаж байсан бол түүний үр дагавар, компани бол түүний томоохон охин компани нь шүүхээс томилогдсон эрх шилжүүлэн авах этгээдийн мэдэлд шилжсэн болон бусад ижил төстэй үйл явдлууд орно.
5. Үнэт цаасыг санал болгох өдөр хүртэлх сүүлийн 3 жилд хийсэн томоохон хөрөнгө оруулалт, чиглэл бүрээр, тэдгээрийн хэмжээ (өөр компанид оруулсан хөрөнгө оруулалт хамаарна);
6. Одоо үргэлжилж байгаа томоохон хөрөнгө оруулалтын хэмжээ, байршлаар /дотоодод, гадаадад), мөн санхүүгийн эх үүсвэр /дотоод, гадаад/-ийн талаарх мэдээлэл;
7. Өмнөх болон тухайн санхүүгийн жилд гуравдагч этгээд компанийн хяналтын багц хувьцааг худалдан авахаар, эсхүл компани өөрөө бусад компанийн хяналтын багц хувьцааг худалдан авахаар тендер санал зарласан эсэх. Зарласан бол уг саналын үнэ.

### **B. Эрхэлж буй бизнесийн ерөнхий мэдээлэл.**

Энэ хэсэгт заасан мэдээллийг санхүүгийн тайланд ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг баримтлан бэлдэнэ. Дараах мэдээллийг тусгана:

1. Компанийн үйл ажиллагааны мөн чанар, эрхэлдэг гол үйл ажиллагаа. Өнгөрсөн 3 жил бүрт борлуулсан бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний нэр төрөл. Шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсэн эсэх. Боловсруулалтын шатанд байгаа шинэ болон шинэчлэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээр нь боловсруулалтын ямар шатанд явж байгаа
2. Компанийн үндсэн зах зээл, сүүлийн 3 жил бүрт эрхэлсэн үйл ажиллагааны төрөл, олсон нийт орлогыг газар зүйн байршил бүрээр ангилан харуулна.
3. Компанийн үндсэн үйл ажиллагаа нь улирлын чанартай эсэх талаар;
4. Түүхий эдийн гол бэлтгэн нийлүүлэгч, үндсэн түүхий эдийн үнэ хэр хэлбэлзэлтэй байдаг талаар;
5. Компанийн ашигладаг маркетингийн болон борлуулалтын арга хэлбэр, тухайлбал хэсэгчилсэн төлбөртэй борлуулалтын арга г.м
6. Компанийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх өөрөөр хэлбэл, компанийн борлуулалт, ашиг орлогод мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх патент, лиценз, бэлтгэн нийлүүлэлт, зээл, борлуулалтын гэрээ, үйлдвэрлэлийн шинэ дамжлагын талаар;
7. Компани өөрийн үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх байр суурь, өрсөлдөх чадвартай холбоотойгоор хийсэн дүгнэлтийн үндэслэл;
8. Компанийн эрхлэж буй үйл ажиллагаанд чухал нөлөөтэй төрийн зохицуулалт, зохицуулах байгууллагын нэр.

В. Зохион байгуулалтын бүтэц. Хэрэв компани нь компанийн нэгдэлд хамаардаг бол уг нэгдлийн талаар болон нэгдэл дэх компанийн байр суурийн талаар танилцуулна. Компанийн охин болон хараат компанийн нэр, хууль ёсны хаяг, тэдгээр дэх эзэмшлийн хувь, эзэмшлийн хувиас ялгаатай бол санал өгөх эрх зэргийг жагсаалтаар харуулна.

Г.Өмч, үйлдвэр, тоног төхөөрөмж. Томоохон үл хөдлөх хөрөнгө, үүний дотор түрээслэсэн болон барьцаалсан хөрөнгийн талаарх мэдээлэл. Мэдээлэлд хөрөнгийн хэмжээ, зориулалт, хүчин чадал, компанийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглагдсан хугацаа, хөрөнгийг ашиглаж буй байдал, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, байршлын талаарх мэдээллийг оруулна. Компанийн хөрөнгөд байгаль орчны нөлөөлөл байгаа бол тайлбарлана. Хүчин чадлаа нэмэгдүүлэх талаар ямар нэг бодитой төлөвлөгөө байгаа эсэх, байгаа бол ямар чиглэлээр юу хийх гэж байгаа, шалтгаан нь юу болох, төлөвлөж буй санхүүжилтийн арга хэлбэр, хэмжээ, уг арга хэмжээг эхлэх дуусгахаар төлөвлөсөн огноо, хэрэгжүүлсний дараа хүчин чадал хэрхэн нэмэгдэх тухай мэдээлнэ.

## **V. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТОЙМ, ХЭТИЙН ТӨЛӨВ**

Энэ хэсэгт танилцуулгад тусгасан санхүүгийн тайлангийн хугацаанд санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн гол хүчин зүйлс болон ирээдүйд компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд бодит нөлөө үзүүлэхүйц хүчин зүйл, хандлагын талаарх менежментийн үнэлгээ, дүгнэлтийг харуулна.

Компанийн үйл ажиллагааг бүхэлд нь ойлгоход шаардлагатай мэдээлэл болох компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд гарсан томоохон өөрчлөлтийг жил бүрийн болон улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд үндэслэн тодорхойлж, өөрчлөлтийн шалтгааныг

тайлбарлана. Энэхүү мэдээллийг компанийн үйл ажиллагааны голлох салбар бүрээр тодорхойлсон байвал зохино. Доор заасан болон компанийн санхүүгийн байдал, түүнд гарсан өөрчлөлт, үйл ажиллагааны үр дүнгийн талаар хөрөнгө оруулагч ойлгож мэдэхэд шаардлагатай бусад мэдээллийг тусгана.

#### А. Үйл ажиллагааны үр дүн.

Компанийн үйл ажиллагааны орлогод нөлөөлж буй гол хүчин зүйлс түүний дотор хэвийн бус, тогтмол бус тохиолддог үйл явдал, шинэчлэл зэргийн талаар болон эдгээр нь чухам ямар орлогод нөлөөлсөн талаар судлагааг харуулна. Компанийн үйл ажиллагааны үр дүнг тодорхойлоход чухал ач холбогдолтой орлого болон зардлын томоохон зүйл ангийг дэлгэрүүлж үзүүлнэ.

1. Цэвэр борлуулалт болон орлогын өөрчлөлт, түүнд борлуулсан бараа, үйлчилгээний хэмжээ, бүтэц, үнэ эсхүл шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ зэрэг нь хэрхэн нөлөөлсөн талаарх судалгаа.
2. Хэрэв мэдэгдэхүйц бол инфляцийн нөлөөг харуулна. Өндөр инфляцитай улсын мөнгөн тэмдэгтээр санхүүгийн тайланг гаргасан бол сүүлийн 5 жилээр, жил бүрийн инфляцийн түвшинг үзүүлж, гиперинфляци компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлснийг тайлбарлана.
3. Хэрэв мэдэгдэхүйц бол гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөг харуулна. Гадаад валютаарх цэвэр хөрөнгө оруулалт нь валютийн зээллэг болон бусад хеджингийн хэрэгслээр хедж хийгдсэн эсэх.
4. Төрийн эдийн засаг, санхүү, мөнгөний эсхүл улс төрийн бодлого компанийн үйл ажиллагаанд болон үнэт цаас гаргаж буй орны хувьцаа эзэмшигчдээс хийх хөрөнгө оруулалтад шууд болон шууд бусаар мэдэгдэхүйц нөлөөлж байгаа эсхүл нөлөөлж болох талаарх мэдээлэл.

#### Б. Төлбөрийн чадвар ба хөрөнгийн эх үүсвэр. Үүнд дараах мэдээлэл багтана:

1. Компанийн төлбөрийн чадвар /урт болон богино хугацааны/-тай холбоотой мэдээлэл:

- а/ Төлбөр гүйцэтгэх дотоод, гадаад эх үүсвэрийн талаарх тайлбар, ашиглагдаагүй байгаа боломжит эх үүсвэр. Ажлын капитал хүрэлцээтэй эсэхийг харуулсан тооцоо, хүрэлцээгүй байгаа бол хэрхэн санхүүжүүлэх талаарх тайлбар
- б/ Компанийн мөнгөн гүйлгээний эх үүсвэр, түүний хэмжээ, охин болон хараат компани нь ногдол ашиг, зээл болон урьдчилгаа хэлбэрээр толгой компанидаа хөрөнгө шилжүүлэхэд эрх зүйн болон эдийн засгийн ямар нэг хязгаарлалт хориг байгаа эсэх, хэрэв байгаа бол энэ нь компанийн төлбөрийн чадварт ямар нөлөө үзүүлсэн эсхүл үзүүлж болох тухай
- с/ Тухайн хугацааны эцэст байгаа зээлийн өрийн хэмжээ, зээлийн хэрэгцээ нь улирлын чанартай байдаг эсэх, зээлийн эргэн төлөгдөх хугацаа, зээлжих чадвар, зээлийн ашиглалтад ямар нэг хязгаар тавьдаг эсэх талаарх тайлбар.

2. Ашиглаж буй санхүүгийн хэрэгсэл, өрийн төлөгдөх хугацаа, хүүгийн бүтэцтэй холбоотой мэдээлэл. Санхүүжилтийн бодлого, санхүүгийн эх үүсвэрийн ашиглалтад тавих хяналт, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь ямар валютаар илэрхийлэгдсэн, аль зээллэг нь тогтмол хүүтэй болох, хедж хийх зорилготой санхүүгийн хэрэгслийн ашиглалт зэрэг нөөцийн бодлого, зорилтыг багтаана.

3. Сүүлийн жилийн юмуу улирлын эцсийн байдлаар: томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөө, түүний үндсэн зорилго, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл.

В. Судалгаа шинжилгээ, сайжруулалт, патент, лиценз г.м. Компанийн санхүүжилтээр сүүлийн 3 жилд хийсэн шинжилгээ судлагаа, сайжруулалтад зарцуулсан хөрөнгийн хэмжээ зэрэг компанийн судалгаа, шинжилгээний бодлогын талаарх тайлбарыг мэдээлнэ.

Г. Чиг хандлагын талаарх мэдээлэл. Үйлдвэрлэл, борлуулалт, эд хөрөнгийн чухал чиг хандлага, захиалгын бүртгэл, өртөг болон худалдах үнийн байдлыг сүүлийн санхүүгийн жилийн байдлаар харуулна. Тухайн санхүүгийн жилийн компанийн тасралтгүй үйл ажиллагаанаас олох орлого, ашигт ажиллагаа, төлбөрийн чадвар, хөрөнгийн эх үүсвэрт бодитойгоор нөлөөлж болох, толилуулсан санхүүгийн тайлан нь ирээдүйн үр дүн, санхүүгийн байдлыг бодитойгоор харуулж чадахгүйд хүргэж болох мэдэгдэж буй хандлага, тодорхойгүй байдал, эрэлт, тохиролцоо, үйл явдлын талаар мөн хэлэлцэнэ.

## **VI. ТУЗ-ИЙН ГИШҮҮД, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, АХЛАХ МЕНЕЖМЕНТ БОЛОН АЖИЛЛАГСАД**

Энэ хэсэгт компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, менежерүүдийн талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчдад хүргэж, тэдгээр хүмүүсийн туршлага, мэдлэг боловсрол, шагнал урамшууллын хэмжээ, компанитай ямар холбоотой болох талаар мэдэж, холбогдох дүгнэлт хийх боломж олгох мэдээллийг тусгана.

А. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, судалдгаа, шинжилгээний ажилтан, эрдэмтэд, зохион бүтээгч зэрэг бүтээл нь компанид чухал нөлөөтэй байдаг ажилтантай холбоотой дараах мэдээллийг тусгана.

1. Нэр, ажлын туршлага, чиг үүрэг, компанийн аль салбарт мэргэшсэн;
2. Үнэт цаас гаргагч компаниас өөр газарт эрхэлж буй үйл ажиллагаа /ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад ажилладаг зэрэг/;
3. Төрсөн огноо, эсвэл нас;
4. Дээр дурдагдсан этгээдүүд хоорондоо нэгдмэл сонирхолтой бол энэ тухай;
5. Томоохон хувьцаа эзэмшигч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч зэргийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалд дээрх этгээдээс байгаа бол энэ тухай.

### Б. Шагнал урамшуулал.

ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, захиргааны, хяналтын болон менежментийн нэгжийн гишүүдийн хувьд сүүлийн бүтэн жилийн байдлаар дараах мэдээллийг тусгана:

1. Компани болон охин компаниас тухайн этгээдийн үзүүлсэн үйлчилгээнд нь олгосон нийт хөлс, шагналын хэмжээ, бусад хэлбэрээр хүртсэн ашиг орлого.

Толгой компани бүртгэлтэй улсын зохицуулах байгууллага ийм шаардлага тавьдаггүй, энэ талаар компани нийтэд мэдээлээгүй тохиолдолд эдгээр хүмүүс нь хувь хүний хувьд эдгээр мэдээллийг нийтэд хүргэнэ. Хөлс, урамшууллыг аваагүй байгаа боловч олгохоор тооцсон бол энэ тухай мөн мэдээлнэ. Хэрэв /а/ урамшуулал, эсхүл ашиг хуваах хөтөлбөрийн дагуу хуваарилсан бол уг хөтөлбөр болон тухайн этгээд түүнд хэрхэн оролцсон талаар, /б/ Хувьцааны опционы хэлбэртэй бол, опционы суурь үнэт цаасны хэмжээ, хэрэгжүүлэх үнэ, /хэрэв байгаа бол/ худалдан авах үнэ, опционы дуусгавар болох хугацааны талаарх мэдээллийг өгнө.

2. Компани, түүний охин компаниас тэтгэвэр, түүнтэй ижил төстэй хэт нь үр ашиг хүртээх зорилгоор хадгалсан, хуримтлуулсан мөнгөний нийт дүн.

#### В. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам.

Өөрөөр заагаагүй бол компанийн сүүлийн санхүүгийн жилийн хувьд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, захиргааны, хяналтын болон менежментийн нэгжийн гишүүдийн талаарх дараах мэдээллийг өгнө.

1. Хэрэв тогтоосон бол тухайн албан тушаалын дуусах хугацаа, боломжтой бол тухайн албан тушаалд ажилласан хугацааны талаар;
2. Компанитай болон түүний аль нэг салбартай хийсэн захирлын гэрээ, хугацаа дуусах үед ямар нэг тэтгэмж олгох эсэх талаар тиймгүй бол энэ тухай;
3. Компанийн аудитын ба болон хөлс, урамшууллын Хорооны тухай дэлгэрэнгүй мэдээлэл, үүнд зөвлөлийн гишүүдийн нэр болон зөвлөлийн үйл ажиллагааны журмын талаар товч танилцуулга.

#### Г. Ажилчид.

Сүүлийн гурван жил тус бүрийн хагас жил болон жилийн эцсийн байдлаар байсан ажиллагсдын тоо түүнд гарсан өөрчлөлт, боломжтой бол газар зүйн байршил болон үйл ажиллагааны үндсэн чиглэлээр ангилан харуулсан ажиллагсдын тооны мэдээлэл. Мөн ажилчдын тоонд гарсан огцом өөрчлөлт, удирдлага ба үйлдвэрчний эвлэл хоорондын харилцааны байдлын талаарх мэдээлэл. Хэрвээ компани нилээдгүй тооны түр ажилчид хөлслөн авдаг бол тэдгээр ажилчдын дундаж тоо болон жилд ажилласан дундаж хугацаа сүүлийн жилийн байдлаар.

#### Д. Хувьцааны эзэмшил.

1. VI.Б болон дээр дурдсан хүмүүсийн хувьцааны эзэмшлийн талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээлэл (хүн бүрийн эзэмшиж буй хувьцааны тоо, тухайн төрлийн нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь, тэдгээрийн саналын эрхийн талаарх мэдээллийг багтаах) ба тэдгээрийн опционоор дамжуулан эзэмших тухайн компанийн хувьцааны тоо. Опционы хувьд: нэр ба опционд заасан үнэт цаасны тоо ширхэг; хэрэгжүүлэх үнэ; худалдан авах үнэ; өөр бусад нөхцөл; опционы дуусах өдөр.

2. Цаашид ажилчдад хувьцаа эзэмшүүлэхээр төлөвлөж байгаа бол уг төлөвлөгөөний талаарх мэдээлэл, үүнтэй холбогдон хувьцаа юмуу опцион гаргах баталгаа зэргийг тусгасан байна.

## **VII. ТОМ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БА НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ХЭЛЦЭЛ**

Энэ хэсэгт компанийн хяналтын багц хувьцааг эзэмшигчид, эзэмших боломжтой этгээдийн талаар болон холбоотой этгээдтэй хэлцэл хийсэн эсэх, хийсэн бол тухайн хэлцлийг хуульд заасан журмын дагуу хийсэн эсэх талаарх мэдээлэл тусгагдана.

### А. Том хувьцаа эзэмшигчид.

Компанид мэдэгдэж байгаа болон олон нийтэд хүргэсэн мэдээлэлд үндэслэх бөгөөд боломжит хамгийн сүүлийн өдрөөр гаргасан байх ёстой. Тэдгээрийн эзэмшиж байгаа болон ашиг хүртэгч байдлаар эзэмшиж байгаа хувьцааны тооны талаарх мэдээллийг багтаасан байна:

1. Компанийн саналын эрхтэй хувьцааны 5% , түүнээс дээш хувьцааг ашиг хүртэгч байдлаар эзэмшиж байгаа этгээдийн талаар дараах мэдээллийг толилуулна:
  - а/ Хамгийн сүүлийн боломжит өдрийн байдлаар том хувьцаа эзэмшигчдийн нэрс, хувьцааны тоо болон нийт хувьцаанд эзлэх хувийн талаар болон хэрвээ том хувьцаа эзэмшигч байхгүй бол энэ тухай мэдээлэл;
  - б/ Сүүлийн гурван жилийн хугацаанд том хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд гарсан томоохон өөрчлөлт;
  - в/ Компанийн том хувьцаа эзэмшигчид нь саналын ялгаатай эрхтэй бол энэ тухай үгүй бол тиймгүй тухай тайлбар.
2. Тухайн улсын хөрөнгө оруулагчдын эзэмшилд байгаа үнэт цаасны төрөл, тоо, хувь хэмжээ бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдийн тоо;
3. Компани өөр компани, өөр улсын Засгийн газар, эсвэл хувь хүн, хуулийн этгээдийн хамтарсан болон тус тусын хяналт, эзэмшилд байдаг эсэх, тийм бол тэдгээрийн нэр ба хяналтын мөн чанарын талаар болон санал өгөх эрхтэй хувьцааны тоо ширхэг, хувь хэмжээ тухай товч тайлбар;
4. Компанийн хяналтыг эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болох гэрээ хэлцлийн талаар.

### Б. Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл.

Сүүлийн гурван жилийн эхний жилийн эхнээс баримт бичиг бүрдүүлэх өдөр хүртэлх хугацаанд компани нь а/ нэг эсвэл түүнээс дээш зуучлагчаар дамжуулан шууд болон шууд бусаар хянадаг эсвэл хяналтад нь байгаа эсвэл нэг компанийн хяналт дор байдаг аж ахуйн нэгжтэй; б/ хамтран зүтгэгч, түнштэй; в/ компанид шууд эсвэл шууд бусаар хүчтэй нөлөө үзүүлэх боломжийг тэдэнд олгох хяналтын багц эзэмшигчид болон тухайн хувь хүмүүсийн гэр бүлийн гишүүдтэй; г/ компанийн төлөвлөлт, төлөвлөгөөг хариуцдаг ба эрх бүхий хүн, компанийн үйл ажиллагааг хянах, удирдах захирал, ахлах удирдах ажилтан болон тухайн хувь хүмүүсийн гэр бүлийн гишүүдтэй; д/ в эсвэл г-д заасан хүн, шууд эсвэл шууд бусаар хяналтын багцыг эзэмшигч эсвэл хүчтэй нөлөө үзүүлэх боломжтой хүнтэй хийсэн хэлцэл эсвэл зээлтэй холбоотой дараах мэдээллээр хангана. Үүнд компанийн захирлуудын эзэмшдэг аж ахуйн нэгж эсвэл том хувьцаа эзэмшигчид ба компанийн үндсэн удирдлагын гишүүний эзэмшлийн аж ахуйн нэгж зэрэг багтана. Хувь хүний гэр бүлийн ойрын гишүүн гэдэг нь нөлөөлөх боломжтой эсвэл нөлөөлдөг компанитай хамтран үйл ажиллагаа явуулдаг хүнийг хэлнэ. Түнш, хамтран зүтгэгч гэдэг нь компанид хүчтэй нөлөөлөх, нэгдэж үйл ажиллагаа явуулдаггүй аж ахуйн нэгж юм. Аж ахуйн нэгжид хүчтэй нөлөөлөх нөлөөлөл гэдэг нь аж ахуйн нэгжийн санхүү болон үйл

ажиллагааны бодлогын шийдвэрт оролцох эрх мэдлийг хэлнэ. Компанийн саналын эрхийн 10 хувийг эзэмшигчид компанид нөлөөлөх магадлалтай гэж үзэх ёстой.

1. Компани юмуу түүний аль нэг салбар оролцогч тал нь болсон, агуулга болон хэмжээний хувьд компанид юмуу холбоотой талд чухал нөлөө бүхий бараа, биет болон биет бус хөрөнгө зэрэгтэй холбоотой аливаа хэлцэл эсхүл хийхээр төлөвлөж байгаа хэлцэл.

2. Дээр дурдсан хүмүүст юмуу тэдэнд ашигтай байдлаар компани, толгой компани, салбараас олгосон зээл, эсхүл зээлийн баталгаа гаргасан байдал (аливаа баталгааг багтаасан байна). Ирүүлэх мэдээлэлд хамрагдсан үеийн хамгийн өндөр дүнтэй үлдэгдэл, мэдээлэл гаргах үед төлөгдөөгүй байгаа үлдэгдэл, зээлийн агуулга, зориулалт, ямар хэлбэрээр, ямар үндэслэлээр зээл олгосон, эсхүл баталгаа гаргасан мөн түүнчлэн зээлийн хүүгийн хувь хэмжээний талаарх мэдээлэл.

#### V. Зөвлөх ба шинжээчийн сонирхол.

Зөвлөх эсхүл шинжээчийг тодорхой болзол тавин хөлсөлсөн, эсвэл тэдгээр нь компани болон салбар компанийн хувьцааны тодорхой хувийг эзэмшдэг бөгөөд энэ нь тухайн хувь хүний хөрөнгөнд чухал суурь эзэлдэг, эсхүл компанид шууд болон шууд бус эдийн засгийн сонирхолтой, эсвэл санал болгох ажиллагааны үр дүнгээс сонирхол нь шалтгаалах бол тэдгээрийн мөн чанар, хөлсөлсөн болзлын тухай товч танилцуулга ирүүлэх.

### **VIII. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ**

Энэ хэсэгт танилцуулгад хавсаргасан байх санхүүгийн тайланг тодорхойлон ямар хугацааны санхүүгийн тайланг хамруулсан байх, санхүүгийн тайланг бэлдэхтэй холбоотой асуудлыг тодорхойлно

Хэрвээ компани жилийн санхүүгийн тайлан ба нэгдлийн нэгдсэн санхүүгийн тайлан гаргадаг бол хоёуланг ирүүлсэн байна.

#### A. Нэгдсэн тайлан ба санхүүгийн бусад мэдээлэл

1. Хөндлөнгийн аудитор шалгаж, дүгнэлт гаргасан нэгдсэн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтий хамт ирүүлнэ. Үүнд:

- а/ баланс;
- б/ орлого үр дүнгийн тайлан;
- в/ өмчийн өөрчлөлтийн тайлан
- г/ мөнгөн гүйлгээний тайлан;
- д/ Сангийн яам болон Хорооноос тогтоосон нэмэлт тайлбар тодруулга;
- е/ багц хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоонд гарсан өөрчлөлт.

2. Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийгдсэн сүүлийн гурван жилийн санхүүгийн харьцуулсан тайланг ирүүлсэн байна.

3. Танилцуулгад хавсаргасан бүх санхүүгийн тайланд аудитийн дүгнэлт гаргасан байна. Хэрвээ аудиторуд нь жилийн тайланд дүгнэлт гаргахаас татгалзсан эсхүл гаргасан дүгнэлтэд хариуцлага хүлээхээс татгалзаж байгаа тухай тэмдэглэсэн бол ийнхүү татгалзсан шалтгааныг



дэлгэрэнгүй тайлбарласан байна. Уг санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрөх эсэхийг Хороо тогтооно.

4. Аудитлагдсан санхүүгийн тайлан нь бүртгүүлэх бичиг баримтыг ирүүлэхийн өмнөх хамгийн сүүлчийн санхүүгийн жилийн тайлан байна.

5. Хэрэв баримт бичгийг аудитлагдсан санхүүгийн жилийн тайлан гарснаас хойш 9 сарын дараа бэлтгэж байгаа бол тухайн санхүүгийн жилийн эхний хагас жилийн санхүүгийн тайланг ирүүлнэ.

Уг санхүүгийн тайлан нь баланс, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг агуулсан бол дараах мэдээллийг харуулна:

а/ Хувьцаа эзэмшигчдэд хувь нийлүүлсэн хөрөнгөөс шилжүүлсэн болон хувь нийлүүлэгчдийн хооронд хийсэн гүйлгээнээс бусдаар хувь нийлүүлсэн хөрөнгөнд гарсан өөрчлөлт;

б/ Хувь нийлүүлсэн хөрөнгөнд гарсан нийт өөрчлөлт.

Хэрэв үндсэн санхүүгийн тайланд тусгаагүй бол баланс дахь хувьцаа эзэмшигчдийн удирдлагын бүтцэд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлийг тусгасан мэдээг гаргана.

Танилцуулгад хавсаргасан сүүлийн жилийн тайлангаас хойшхи санхүүгийн байдал ашигт ажиллагаанд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг улирлын санхүүгийн тайланд тусгана. Дээр шаардсаны дагуу ирүүлж байгаа улиралын санхүүгийн тайланг аудиторoor хянуулсан байна.

6. Хэрэв экспорт худалдаа нь компанийн худалдааны нийт дүнгийн чухал хэсгийг бүрдүүлж буй бол нийт худалдаан дахь экспорт худалдааны эзлэх хувь болон дүнг тодотгон өгнө.

7. Компанийн санхүүгийн байдал болон ашигт ажиллагаанд нөлөөлсөн болон ойрын ирээдүйд нөлөөлж болох 3-гч этгээдийн дампуурал зэрэгтэй ижил төстэй шүүх, арбитрын хэрэг байгаа эсэх талаарх мэдээлэл өгнө. Үүнд Засгийн газрын хүлээгдэж буй болон төлөвлөж буй үйл хөдлөлийг оруулан тооцно.

8. Ногдол ашиг хувиарлах талаарх компанийн бодлогыг тусгасан байна.

#### Б. Чухал өөрчлөлтүүд.

Жилийн санхүүгийн тайлан болон хамгийн сүүлийн улирлын санхүүгийн тайлангаас хойш бүртгүүлэх хүртэлх хугацаанд орсон чухал өөрчлөлт бий эсэх талаар мэдээлнэ.

### **IX. САНАЛ БОЛГОХ БОЛОН БҮРТГЭХ**

Энэ хэсэгт үнэт цаасыг санал болгох, бүртгүүлэх, хувиарлахтай холбоотой мэдээлийг тусгана.

#### А. Санал болгох болон бүртгэх тухай дэлгэрэнгүй мэдээлэл.

1. Санал болгох гэж буй үнэт цаасны үнэ эсхүл үнэ тогтоох арга болон гарах зардлын дүн, ялангуяа захиалагч эсхүл худалдан авагчийн зардал .

2. Тухайн үнэт цаасанд тогтворжсон зах зээл байхгүй бол санал болгох үнэ тогтоохдоо ямар үзүүлэлтийг үндэслэсэн, үнэт цаасны варрантийн болон хөрвүүлэх үнэ, үнийг хэн тогтоосон талаарх мэдээллийг агуулсан байна.

3. Компанийн хувьцаа эзэмшигчид хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй эсэх, тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хязгаарласан эсхүл эдлүүлэхгүйгээр шийдвэрлэсэн бол шалтгаан, ингэж шийдвэрлэснээс хэн нэгэнд давуу тал олгож байгаа бол тэр тухай, бэлэн мөнгөөр худалдах бол үнийг тогтоосон үндэслэл

4. Санал болгох эсвэл бүртгүүлэх гэж буй үнийн талаарх дараах мэдээлэл;

- а/ Сүүлийн 5 санхүүгийн жил: жил бүрийн зах зээлийн дээд, доод үнэ;
- б/ Сүүлийн 2 санхүүгийн жилийн улирал бүрийн зах зээлийн дээд, доод үнэ;
- в/ Сүүлийн 6 сар: Сар бүрийн зах зээлийн дээд, доод үнэ;
- г/ Тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий үнэт цаасны хувьд, сүүлийн 6 сар дахь анхдагч арилжааны өдөр, нийтэд санал болгохоо зарлахын өмнөх хамгийн сүүлийн арилжааны өдөр болон танилцуулгаа олон нийтэд танилцуулахаас өмнөх хамгийн сүүлийн өдрийн зах зээлийн үнэ.

Хэд хэдэн зах зээл дээр зэрэг арилжаалагддаг бол зах зээл тус бүрийн үнийн тухай мэдээлэл. Хэрэв сүүлийн 3 жилийн дотор арилжааг түдгэлзүүлсэн тохиолдол байгаа бол энэ тухай, мөн зах зээл дээр үнэт цаас нь тогтмол арилжигдаагүй тохиолдолд, хөрвөх чадваргүй болсон талаар мэдээлэл.

5. Санал болгох болон бүртгэгдэхээр төлөвлөгдөж буй үнэт цаасны төрөл, ангилалыг тодорхойлж, доорх мэдээллүүдийг ирүүлэх:

- а/ Үнэт цаас нь нэрийн эсхүл мэдүүлгийн аль ч хэлбэртэй байсан нийт гаргах хувьцааны болон зах зээлд гаргах хувьцааны төрөл тус бүрийн тоо ширхэг, нэг хувьцааны нэрлэсэн үнэ эсхүл түүнтэй адилтгах үнэ, санал болгох хамгийн доод үнэ. Хэрэв хамт гаргах бол купоны тодорхойлолт
- б/ Хувьцааг шилжүүлэх, хэрэв шилжүүлэхэд ямар нэг хязгаарлалт байгаа бол түүний тухай.

6. Хэрэв санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдсэн эрх нь бусад ангилалын үнэт цаас эсхүл ямарваа нэгэн гэрээ эсхүл бусад бичиг баримтаар гэрчлэгдсэн эрхээр хязгаарлагдсан бол хязгаарлалтын мөн чанар, энэ нь санал болгож буй үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхэд хэрхэн нөлөөлөх тухай.

7. Санал болгож буй энгийн хувьцаанаас бусад үнэт цаасны хувьд түүгээр гэрчлэгдэж буй эрхийн талаар товч тайлбарлах.

- а/ Хэрэв варрант эсхүл эрхийг санал болгож байгаа бол тухайн үнэт цаасаар гэрчлэгдэж буй үнэт цаасны нэр болон тоо хэмжээ, гарсан боловч төлбөр хийгдээгүй байгаа варрант болон эрхийн тоо хэмжээ, хэрэгжүүлэх үнэд өөрчлөлт болон тохиргоо хийх сан, варрант болон эрхийг хэрэгжүүлэх хугацаа, үнэ болон бусад чухал мэдээлэл
- б/ Хэрэв хувьцаа худалдаж авах варрант эсхүл хөрвөх үнэт цаасыг санал болгож байгаа бол: хөрвүүлэх нөхцөл, хөрвүүлэх болон худалдан авах эрхийг хэрэгжүүлэх хугацаа дуусахаас өмнө хэрэгжүүлээгүй бол уг эрх нь хүчингүй болох эсэх, варрант дуусахш хүчингүй болох огноо, үнэт цаасыг худалдан авах болон эргүүлэн авах тухай мэдэгдлийн хугацаа, давтамж, энэхүү мэдэгдлийг хэрхэн хүргэх, мэдүүлгийн үнэт цаасны хувьд худалдан авах эсхүл хөрвүүлэх эрхэ алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах талаарх хариуцлагыг хөрөнгө оруулагчид хүлээх тухай мэдэгдэл.

## Б. Хуваарилах төлөвлөгөө

1. Андеррайтинг хийж байгаа эсхүл бүртгэгдэж байгаа үнэт цаасанд баталгаа гаргаж буй хуулийн этгээдийн нэр, хаяг

2. Санал болгон гаргаж буй үнэт цаасыг том хувьцаа эзэмшигчид, захирлууд эсхүл компанийн удирдлагын эрх бүхий албан тушаалтнууд авахаар төлөвлөж байгаа бол энэ тухай, санал болгож буй хувьцааны 5%-иас илүүг авахаар төлөвлөж буй этгээдийн тухай

3. Үнэт цаасыг санал болгож буй хөрөнгө оруулагчдын зорилтот бүлгүүдийн тухай мэдээлэл. Үнэт цаасыг 2 болон түүнээс дээш улсад нэгэн зэрэг гаргах бөгөөд үнэт цаасыг хэсэглэн гаргахаар нөөцөлж байгаа тохиолдолд нөөцийн талаарх мэдээлэл

4. Одоогийн хувьцаа эзэмшигчид, захирлууд, эсхүл компанийн болон түүний охин компанийн ажилтан, хуучин ажиллаж байсан хүмүүс гэх мэт зорилтот хөрөнгө оруулагчдад үнэт цаасыг хуваарилахаар нөөцөлсөн бол энэ талаарх мэдээлэл, давуу эрхээр хуваарилахаар төлөвлөж байгаа талаарх бусад мэдээлэл.

5. Андеррайтерийн худалдах үнэт цаас нь гаргаж буй үнэт цаасны тоо хэмжээнээс хэтэрсэн тохиолдол санал болгож буй үнэт цаасны тоо хэмжээг хэдий хэмжээгээр нэмж болох талаар тодорхойлох.

6. Үнэт цаас нь андеррайтераар дамжин хуваарилагдахгүй тохиолдолд хуваарилалтын төлөвлөгөөг харуулах. Хэрэв үнэт цаасыг брокер, дилерийн компаниар дамжуулан худалдах бол хуваарилалтын төлөвлөгөө, гэрээг ирүүлэх. Санал болгоход оролцох брокер, дилер болон тд тус бүрдээ хэдий хэмжээний үнэт цаас санал болгох тухай

7. Арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан дуудах опцион хэлбэрээр санал болгох тохиолдолд энэ гүйлгээний тухай товч дурьдах.

8. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх гэж байгаа хувьцааны нэг хэсгийг нэгэн зэрэг хаалттай байршуулахаар бол энэ тухай нарийвчилсан мэдээлэл, хаалттай болон нээлттэй худалдах хувьцааны тоо ширхэг

9. Андеррайтер болгоны хариуцан борлуулах үнэт цаасны тоо ширхэг зэргийг багтаасан андеррайтеруудын синдикатын тухай мэдээлэл. Андеррайтерийн ажиллагааг ямар хэлбэрээр хийх тухай мэдээлэл: үнэт цаасыг бүхэлд нь худалдаж авах болон худалдан авах амлалт гаргах эсхүл зуучлагчаар ажиллах, эсхүл андеррайтерууд зөвхөн нийтэд санал болгон худалдаж чадах үнэт цаасныхаа төлбөрийг хийх буюу “дээд зэргийн хүчин чармалт гаргах” хэлбэр зэргийг багтаасан байна.

10. Хэрвээ андеррайтер бусад зөвлөх компанитай материаллаг холбоотой бол энэ талаарх нөхцөл байдлыг тайлбарласан байна.

## В. Зах зээл.

Компани нь үнэт цаасаа бүртгүүлэх арилжаа эрхлэх байгууллагын тухай мэдээлнэ. Гэхдээ тухайн арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрчихсөн байгаа мэт сэтгэгдэл төрөлхүйц байдлаар мэдээлэхийг хориглоно.

## Г. Худалдаж байгаа хувьцаа эзэмшигч.

Дор дурдсан мэдээллийг ирүүлнэ.

1. Хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдаж байгаа компанийн хувьцаагаа нийтэд худалдахаар санал болгож буй этгээдийн нэр, хаяг, албан тушаал, компани, түүний өмнөх үүрэг хэрэгжүүлэгч болон салбартай худалдаж байгаа этгээд нь сүүлийн 3 жилд материаллаг холбоотой байсан эсэх;

2. Худалдаж байгаа этгээд бүрийн санал болгож буй үнэт цаасны тоо, төрөл болон хувь нийлүүлсэн хөрөнгөд эзэлж байгаа хувь. Санал болгохын өмнө болон дараа худалдаж буй этгээдийн ашиг хүртэгч байдлаар эзэмших үнэт цаасны тоо хэмжээ, хувь.

#### Д.Хувьцааны эзэмшлийн харьцааны өөрчлөлт.

Дор дурдсан мэдээллийг ирүүлнэ.

1. Өмчлөлийн үнэт цаасыг нийтэд санал болгох үнэ болон захирлууд, ахлах менежерүүд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн сүүлийн 5 жилд авсан эсхүл авах эрхтэй тухайн үнэт цаасны өртөг нь хоорондоо мэдэгдэхүйц зөрүүтэй бол энэ тухай;
2. Нэгж хувьцааг санал болгох үнэ ба нэгж хувьцааны балансын цэвэр үнийн зөрүүг хамгийн сүүлийн балансын үзүүлэлтэд үндэслэн тооцож, нэмж хувьцаа гаргаснаар одоогийн өмчлөлд гаргах тоо, болон бүтцийн өөрчлөлтийг харуулна;
3. Одоогийн хувьцаа эзэмшигчдээс захиалга авах замаар санал болгох тохиолдолд хэрвээ тэдгээр нь шинэ гаргалтаас захиалахгүй бол хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, эзэмшилд гаргах өөрчлөлтийн талаарх мэдээлэл.

#### Е. Үнэт цаас гаргах зардал.

Дор дурдсан мэдээллийг ирүүлнэ.

1. Андеррайтер, бусад зуучлагчид болон компанийн хооронд тохиролцсон хямдруулалтын нийт дүн болон шимтгэлийн дүн, үүнээс гадна санал болгож буй нийт дүнгээс авах шимтгэлийн дүнгийн хувь эсхүл нэгж хувьцааны хямдруулалт, шимтгэлийн дүнг тусгана.
2. Үнэт цаасыг бүртгүүлэх, санал болгох гаргалт болон борлуулахтай холбоотой томоохон зардлуудыг төрлөөр нь жагсаасан тайлан болон компаниас бусад этгээд уг зардлыг төлөх бол хэн болохыг талаарх мэдээлэл ирүүлэх. Уг мэдээлэл нь ирээдүйд гарах зардал байж болох аливаа зардлын дүн тодорхойгүй нөхцөлд төсөөлөл байдлаар ирүүлнэ.

### **Х. НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ**

#### А. Хувь нийлүүлсэн хөрөнгө.

Дор дурдсан мэдээлэл нь хамгийн сүүлийн санхүүгийн тайланд үндэслэсэн байна.

1. Нийт гаргасан хувьцааны дүн нь хувьцааны төрөл тус бүрээр:
  - а/ Зарласан хувьцааны тоо;
  - б/ Төлбөр бүрэн хийгдсэн гаргасан хувьцаа болон төлбөр бүрэн хийгдээгүй гаргасан хувьцааны тоо;
  - в/ Хувьцааны нэрлэсэн үнэ эсхүл нэрлэсэн үнэгүй бол энэ тухай;
  - г/ Гаргасан хувьцааны төлбөр тооцоо жилийн эхэнд болон эцсийн байдлаар.

Хэрвээ сүүлийн 5 жилд хөрөнгийн 10 хувь ба түүнээс дээш хэмжээний төлбөр бэлэн мөнгөнөөс бусад хөрөнгөөр хийгдсэн бол энэ тухай дурдана.

2. Компани өөрөө, эсхүл түүний нэрийн өмнөөс болон охин, салбар компанийн эзэмшиж байгаа хувьцааны тоо ширхэг, балансын үнэ болон нэрлэсэн үнэ.

3. Хэрвээ компанид зарласан боловч гаргаагүй хувьцаа байгаа, эсхүл варрант, хөрвөх өрийн бичиг, бусад хувьцаатай холбоотой үнэт цаас эсхүл захиалах баталгаатай эрх зэрэг хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх аливаа эрх байгаа бол дор дурдсан мэдээллийг тусгасан байна.

4. Хувьцаатай холбоотой гаргасан үнэт цаасны хэмжээ болон тухайн үнэт цаастай холбоотойгоор хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдэх хэмжээ, тухайн үнэт цаасаар гэрчлэгдсэн хөрвүүлэх эрхийн хугацаа:

- а/ нэмэлт хувьцаа гаргасан тохиолдоод захиалах давуу эрхтэй этгээдийн ангилал;
- б/ үүнтэй холбогдсон хувьцаа нэмж гаргах нөхцөл, зохион байгуулалтын арга хэмжээ, хэрэгжүүлэх ажиллагаа.

5. Сүүлийн 3 жилд хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнд орсон өөрчлөлт, өөрчлөхөд хүргэсэн үйл явдлын тухай мэдээлэл, үүнд: хувьцааны тоо, төрөл, хувьцааны төрөл тус бүрийн санал эрхэд гарсан өөрчлөлтийн талаарх тайлбарын хамт ирүүлнэ. Нэмж хувьцаа гаргасан бол үнэ, гаргасан нөхцөл зэргийг тайлбарлах бөгөөд төлбөрийг бэлэн бусаар хийсэн, хямдруулалт, тусгайлсан хугацаа, үечилсэн төлбөр тооцоо хийх зэрэг нөхцөл байсан бол тодорхойлно. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ буурсан болон өөрийн хөрөнгийн харьцаа буурсан бол шалтгааныг тайлбарлана.

#### Б. Компанийн дүрэм болон бусад журмаар тогтоосон дараах асуудлын талаарх мэдээллийг ирүүлнэ.

1. Компанийн дүрэмд заасан компанийн зорилго, зорилтыг тайлбарлах.

2. Компанийн дүрэм, бусад дотоод журамд захирлуудтай холбоотой тусгасан аливаа нөхцлүүдийн талаарх мэдээлэл.

- а/ Захирлууд сонирхогч этгээд болох аливаа санал, арга хэмжээ ба хэлцэлд захирлуудын санал өгөх эрх, түүнийг хязгаарладаг эсэх;
- б/ Хараат бус гишүүнгүй нөхцөлд өөрсдийн болон ТУЗ-ийн хороодын гишүүдэд нөхөн олговор олгох асуудлаар санал өгөх эрх хэмжээ;
- в/ Захирлуудын зээлжих эрх хэмжээ, түүний хязгаар;
- г/ Захирлуудын тэтгэвэрийн төлөвлөгөө, тэтгэвэрийн насанд хүрээгүй бол хэрхэх;
- д/ Хэрвээ тогтоосон бол захирлаар ажиллахад шаардагдах хувьцааны доод хэмжээ.

3. Хувьцааны төрөл тус бүрээрх олгогдсон эрх, давуу эрх ба хязгаарлалт:

- а/ Ногдол ашгийн эрх, хэрэв ногдол ашийн эрх нь хугацаатай бол энэ тухай, энэ эрхийг эдлэх этгээдүүдийн тухай;
- б/ Саналын эрх, ТУЗ-ийн гишүүд нь дахин сонгогдохоор нэрээ дэвшүүлэх тодорхой хугацаа тогтоосон бол кумулятив аргаар ТУЗ-ийг сонгодог нь үүнд хэрхэн нөлөөлөх тухай;
- в/ Компанийн ашгаас хувь хүртэх эрх;
- г/ Компанийг татан буулгахад хөрөнгөөс хувь хүртэх эрх;

- д/ Эргүүлэн худалдан авах нөхцлүүд;
- е/ Компанийн бондын эргэн төлөлтийг хийх нөхцөлүүд;
- ё/ Тухайн томоохон багц хувьцаа эзэмшдэг болон эзэмших этгээдийн талаар ямар нэгэн ялгаварлах бодлого явуулдаг бол энэ тухай.

4. Хувьцаа эзэмшигчийн эрхийг өөрчлөхөд хүргэх үйл явдлууд.

5. Хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит болон ээлжит бус хурал зарлан хуралдуулах ба оролцох нөхцөл.

6. Үнэт цаас эзэмших эрхийг аливаа хэлбэрээр хязгаарладаг бол энэ тухай: Үүнд гадаад улсын хууль, компанийн дүрэм, бусад албан ёсны баримт бичигт заасан гадаадын иргэн үнэт цаас эзэмших, саналын эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой хязгаарлалтын асуудлыг багтаасан байна. Хэрвээ аливаа хязгаарлалт байхгүй бол энэ тухай мэдээлнэ.

7. Компанийн дүрэм, журамд нэгтгэх, хяналтын багцыг худалдан авах, компанийг өөрчлөн байгуулах зэргээр компанийн хяналтад өөрчлөлт орохоос сэргийлэх, саад хийх, хойшлуулахтай холбоотой заалтууд байгаа эсэх.

8. Хувьцаа эзэмшигч нээлттэй болговол зохих эзэмшлийн хязгаарыг тогтоосон журмын тухай.

9. Дээр дурдсан 2-8 хүртэлх асуудлыг зохицуулсан үнэт цаас гаргаж байгаа орны хууль тогтоомж нь компанийн бүртгэлтэй орны хууль тогтоомжоос ихээхэн ялгаатай бол тухайн асуудлуудаарх хуулийн нөлөөллийг тайлбарлана.

10. Компанийн дүрэм бусад адилтгах баримт бичигт заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой заалт нь хуулиар шаардсанаас илүү хатуу нөхцөлтэй бол энэхүү нөхцлийг тайлбарлана.

## В. Томоохон гэрээ

Бүртгүүлэх бичиг баримтыг ирүүлэхээс өмнөх 2 жилд байгуулсан бөгөөд компани эсхүл түүний аль нэг гишүүн нь оролцогч тал болж байгаа өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаанаас бусад томоохон гэрээ бүрийн танилцуулга, үүнд: гэрээний тал, нөхцөл, товч мэдээллийг ирүүлэх.

## Г. Зах зээлийн хяналт зохицуулалт

Дор дурдсан асуудалд нөлөөлөх компанийн үйл ажиллагаа явуулж буй орны хууль, тогтоомж, журам болон бусад хууль эрх зүйн баримт бичгүүдийг тайлбарлах

1. Хувьцааны экспорт, импорт болон үүнд компанийн групп мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг шилжүүлэх боломжийг багтаасан байна.

2. Компанийн хувьцааг эзэмшигч гадаадын этгээдэд ногдол ашиг, хүү болон бусад төлбөрийг төлөх.

## Д. Татвар

Компани нь тухайн оронд байгаа хувьцаа эзэмшигчидэд татвартай (орлогын татварын нөхцлийг багтаана) холбоотой асуудлыг тусгана.

## Е. Ногдол ашиг ба төлбөрийн агентууд

Ногдол ашигт тавих хязгаарлалт, зарлах, олгох өдөр, тухайн оронд оршин суугч бус этгээд ногдол ашгаа хэрхэн хүртэх талаарх мэдээллийг нээлттэй болгоно. Бүртгэл хийж буй эсхүл бүртгэл хийхээр төлөвлөгдөж байгаа оронд хувьцааг албан ёсны бүртгэлд оруулах үедээ компанийн төлбөрийн агентаар ажиллах санхүүгийн байгууллагын тодорхой болгох.

**Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх асуудлыг Хорооны хуралдаанд оруулах танилцуулгын агуулга**

1. Хорооны шийдвэрийн төсөл, түүний танилцуулгыг боловсруулсан мэргэжилтэн, хянасан, танилцсан, хуралдаанд оруулахыг зөвшөөрсөн тухай мэдээлэл;
2. Үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш гүйцэтгэсэн ажиллагааны танилцуулга;
3. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, түүхийн талаарх мэдээлэл, үнэт цаас гаргагчийн хөрөнгө, санхүүгийн үзүүлэлтүүд;
4. Үнэт цаасны талаарх мэдээлэл, үнэт цаас гаргаж санхүүжүүлэхээр төлөвлөж буй төсөл, төлөвлөгөөний тухай мэдээлэл;
5. Хөрөнгө оруулагчдад учирч болох эрсдэлийн талаарх мэдээлэл;
6. Шийдвэрийн төслийн агуулга, холбогдох тайлбар;
7. Үнэт цаас бүртгэх эсэх асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал, саналын үндэслэл, шаардлагатай гэж үзсэн зөвлөмж;
8. Үнэт цаасыг бүртгэхээс татгалзах тухай шийдвэрийн төсөл боловсруулсан бол уг шийдвэрийн үндэслэл, түүний тайлбар;
9. Үнэт цаасыг бүртгэх тухай шийдвэрийн төсөл боловсруулсан бол үнэт цаас бүртгүүлсний дараа уг үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагааны тухай мэдээлэл;
10. Энэхүү танилцуулгад тухайн үнэт цаасны бүртгэлийн болон товч танилцуулгыг хавсаргасан байна. Шаардлагатай гэж үзвэл бусад баримт материалын хуулбарыг хавсаргаж болно.



## НИЙТЭД САНАЛ БОЛГОН ҮНЭТ ЦААС ГАРГАСАН ТУХАЙ ТАЙЛАН

### А.Тайлангийн нүүрний хуудас

Үнэт цаас гаргагчийн нэр, хаяг, байршил-----

Үнэт цаасны нэр, төрөл -----

Үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрсөн Хорооны шийдвэрийн огноо-----

Үнэт цаас гаргагчийн:

- Гүйцэтгэх захирлын нэр, гарын үсэг -----

- Ерөнхий нягтлан бодогч нэр, гарын үсэг -----

Үнэт цаас гаргагчийн

Тэмдэг

Тайлан гаргасан огноо:

### Б.Тайлангийн агуулга:

1. Шинээр болон нэмж гаргасан үнэт цаасыг арилжаалж эхэлсэн болон дууссан огноо;  
Үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдсан бол төлбөр хийгдсэн хэлбэр, огноо;  
Өрийг хувьцаагаар сольсон бол төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагад хувьцааг авлагатай этгээдийн нэр дээр бүртгэсэн огноо;  
Бондыг /өрийн бичиг/ багц багцаар нь хэсэгчлэн худалдсан бол багц бүрийг худалдсан огноо;
- 2.Гаргасан үнэт цаасны нэрлэсэн үнэ;
- 3.Худалдсан үнэт цаасны тоо;
- 4.Худалдсан үнэт цаасны арилжааны дээд, доод, дундаж ханш;  
Хэрвээ үнэт цаасыг захиалгын журмаар хаалттай хүрээнд худалдсан бол түүний үнэ;  
Хэрвээ өрийг хувьцаагаар сольсон бол нэгж хувьцааны үнийг хэдэн төгрөгөөр тооцсон;
- 5.Үнэт цаасны төлбөрийн тухай мэдээлэл:
  - а/ мөнгөн хөрөнгө, үүнээс үндэсний болон гадаад валютаар хийгдсэн төлбөр;
  - б/ оюуны өмч, оюуны өмчөөр төлбөр хийсэн этгээдийн нэр, Оюуны өмчийн газарт бүртгэгдсэнийг нотлох баримт, үнэ, үнэлсэн тухай мэдээлэл;

в/ эд хөрөнгийн хэлбэрээр төлбөр хийгдсэн бол уг хөрөнгийн үнэ, үнийг тогтоосон үндэслэл, үл хөдлөх хөрөнгө бол түүний гэрчилгээ үнэ тогтоосон эрх бүхий байгууллагын дүгнэлт, эргэлтийн хөрөнгө бол уг хөрөнгийн үнийг зөвшөөрч баталсан эрх бүхий этгээдийн шийдвэрийн огноо, дугаар;

г/ эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хийгдсэн бол төлбөрт тооцож эд хөрөнгө эзэмших эрхээ шилжүүлсэн этгээдийн нэр, уг эрхийг эзэмшигч болохыг болон уг эрхийг үнэт цаас гаргагчид шилжүүлснийг нотолсон баримт;

6. Үнэт цаасыг нэрлэсэн үнээс дээгүүр үнээр худалдан борлуулснаас орсон нэмэгдэл орлогын хэмжээ үнийн дүнгээр.

7. Бүх төрлийн үнэт цаасыг худалдан борлуулахад хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, уг хэлцлийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрийн хуулбар.

8. Хувьцаа гаргасан тухай тайлан гаргаж байгаа бол гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт худалдан авсан этгээдийн нэр, нийт эзэмшиж буй хувьцааны тоо, хувь.

Хувьцаат компани шинээр байгуулагдахад гаргасан хувьцааны тайлан гаргаж байгаа бол шинээр байгуулагдсан хувьцаат компанийн эрх бүхий албан тушаалтны нэр, овог, эзэмшиж буй хувьцааны тоо, хувь.

Тайлбар: Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, компанийн эрх бүхий албан тушаалтныг Компанийн тухай хуульд заасны дагуу тодорхойлно.